

ТАВАНТОЛГОЙ ТҮЛШ ХХК

Тендер
шалгаруулалтын
нэр:

Тендер
шалгаруулалтын
дугаар:

Холбоо дохиолол камержуулалт худалдан авах

TTTXXK/20240102166

2024 он

I БҮЛЭГ.ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА (ТШЗ)

I БҮЛЭГ.ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА (ТШЗ)	1
1. Тендерийн цар хүрээ	1
2. Санхүүжилтийн эх үүсвэр болон төсөвт өртөг.....	1
3. Худалдан авах ажиллагааны хууль тогтоомж	1
4. Сонирхогч этгээд, оролцогч.....	2
5. Түншлэлийн болон туслан гүйцэтгүүлэх гэрээ	2
6. Нийлүүлэх барааны гарал үүсэл.....	2
7. Тендер шалгаруулалтын баримт бичиг	2
8. Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах	3
9. Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт	3
10. Тендер шалгаруулалтын баримт бичгийн болон тендерийн хэл..	3
11. Тендерийн иж бүрдэл	4
12. Тендерийн жишиг маягтууд	4
13. Хувилбарт санал	4
14. Ерөнхий шаардлагыг магадлахад шаардлагатай баримт бичиг	5
15. Санал болгож буй бараа тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг	5
16. Чадавхын болон туршлагын шаардлага	6
17. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт.....	7
18. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт ..	7
19. Тендерийн үнэ ба үнийн хөнгөлөлт.....	7
20. Тендерийн валют	8
21. Тендер хүчинтэй байх хугацаа	8
22. Тендерийн баталгаа	9
23. Тендер баталгаажуулах, илгээх	9
24. Тендер хүлээн авах эцсийн хугацаа	9
25. Тендерийн талаар тодруулга авах.....	9
26. Тендерийг шаардлагад нийцсэн эсэхийг хянан үзэх.....	10
27. Тендерийг үнэлэх.....	10
28. Арифметик алдааг залруулах	10
29. Оролцогчид давуу эрх олгох	10
30. Үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт	10
31. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлох	10
32. Тендерийг эрэмбэлэх	10
33. Оролцогчийн чадавхыг дахин магадлах	10
34. Мэдэгдэл хүргүүлэх	11
35. Гүйцэтгэлийн баталгаа	11
36. Гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах	11

I БҮЛЭГ. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА (ТШЗ)

A. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1. Тендерийн цар хүрээ**
- 1.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “Хууль” гэх)-ийн дагуу өгөгдлийн хүснэгтэд заасан захиалагч III бүлэгт тодорхойлсон бараа, түүний дагалдах үйлчилгээ (цаашид “бараа” гэх) худалдан авахаар тендер шалгаруулалтыг зохион байгуулна. Тендер шалгаруулалтын нэр болон дугаарыг өгөгдлийн хүснэгтэд заана.
- 1.2. Тендер шалгаруулалт багцтай бол энэ тухай мэдээллийг өгөгдлийн хүснэгтэд заана.
- 1.3. Барааг бүхэлд нь, эсхүл түүний тодорхой багцын барааг хуулийн 8.1-д зааснаар дотоодын үйлдвэрлэлээр хангах боломжтой бол энэ тухай захиалагч өгөгдлийн хүснэгтэд заана. Ийнхүү заасан бол тендер шалгаруулалт, эсхүл түүний багцад зөвхөн Монгол Улсын гарал үүсэлтэй бараа нийлүүлнэ.
- 1.4. Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа үед энэ тухай өгөгдлийн хүснэгт болон зарлалд заана.
- 2. Санхүүжилтийн эх үүсвэр болон төсөвт өртөг**
- 2.1. Тендер шалгаруулалтын нийт болон багц тус бүрийн санхүүжилтийн эх үүсвэр, батлагдсан төсөвт өргтийг өгөгдлийн хүснэгтэд тусгана.
- 3. Худалдан авах ажиллагааны хууль тогтоомж**
- 3.1. Энэ худалдан авах ажиллагаанд хуулийн 2.1-д заасан төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг дагаж мөрднө.
- 4. Худалдан авах ажиллагааны цахим систем**
- 4.1. Тендер шалгаруулалтыг Сангийн сайдын баталсан “Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам”-ын дагуу худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn) /цаашид “цахим систем” гэх/-ээр зохион байгуулна.
- 5. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх**
- 5.1. Захиалагч, сонирхогч этгээд, оролцогч болон хуулийн 52.1-д заасан ажилтан, албан тушаалтан Авлигын эсрэг хууль, Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль, Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуулиар хориглосон үйлдэл, эс үйлдлийн талаар холбогдох албан тушаалтан, хууль хяналтын байгууллагад хууль тогтоомжийн дагуу мэдэгдэнэ.
- 5.2. Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20, 20¹, 21 дүгээр зүйлд заасан хориглолт, хязгаарлалтад хамаарах этгээд тендер шалгаруулалтад оролцох эрхгүй байна.

- 6. Сонирхогч оролцогч** **этгээд,** **6.1.** Оролцогч хуулийн 6 дугаар зүйлд нийцүүлэн тендер ирүүлнэ.
6.2. Оролцогчтой холбоотойгоор хуулийн 7.1-д заасан нөхцөл үүсээгүй буюу өрөнхий шаардлагыг хангасан байна.
6.3. Монгол Улсын олон улсын гэрээнд үл нийцэх, худалдааны хоригт хамаарах этгээд тендер ирүүлэх эрхгүй.
6.4. Тендер шалгаруулалтад оролцох сонирхлоо илэрхийлэх аж ахуй эрхлэгч нь хуулийн 22.10-т заасан үйлчилгээний хураамж төлсөн байна.
6.5. ТШЗ-ны 6.4-т заасан үйлчилгээний хураамжийг аливаа үндэслэлээр буцаан олгохгүй.
- 7. Түншлэлийн болон туслан гүйцэтгүүлэх гэрээ** **7.1.** Тендерт ирүүлэх түншлэлийн гэрээ, туслан гүйцэтгүүлэх гэрээ нь хуулийн 6 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан байна.
7.2. Туслан гүйцэтгүүлэх гэрээ хуулийн 6.4-т заасныг зөрчсөн бол захиалагч тухайн туслан гүйцэтгүүлэх гэрээ, туслан гүйцэтгэгчид холбогдох баримт бичгийг тендер хянан үзэхэд харгалзан үзэхгүй.
7.3. Түншлэлийн болон туслан гүйцэтгэгчийн хувиар оролцохыг зөвшөөрсөн болохыг түншлэлийн гишүүн болон туслан гүйцэтгэгч цахим системээр баталгаажуулсан байна.
7.4. ТШЗ-ны 7.3-т заасан нь гадаадын этгээд түншлэлийн гишүүн, эсхүл туслан гүйцэтгэгчээр ороход хамаарахгүй.
7.5. Түншлэлийн гишүүн, туслан гүйцэтгэгч тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэгдсэн хугацаа дуусгавар болоогүй бол шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.
- 8. Нийлүүлэх барааны гарал үүсэл** **8.1.** ТШЗ-ны 1.3-т өөрөөр заагаагүй бол гэрээгээр нийлүүлэх бараа нь аль ч улсын гарал үүсэлтэй байж болно.
- Б.АГУУЛГА**
- 9. Тендер шалгаруулалтын баримт бичиг** **9.1.** Тендер шалгаруулалтын баримт бичиг нь доор дурдсан бүлэг болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөс бүрдэнэ:
I Бүлэг. Тендер шалгаруулалтын зааварчилгаа;
II Бүлэг. Өгөгдлийн хүснэгт;
III Бүлэг. Техникийн тодорхойлолт, тавигдах шаардлага;
IV Бүлэг. Тендерийн үнэлгээний шалгуур үзүүлэлт;
V Бүлэг. Тендерийн жишиг маягт;
VI Бүлэг. Гэрээний нөхцөл.
9.2. Захиалагч тендер шалгаруулалтын үр дүнд нийлүүлэгчтэй гэрээ байгуулахад тендер шалгаруулалтын баримт бичгийн VI бүлэг дэх гэрээний нөхцөлийг баримтална.

- 9.3. Сонирхогч этгээд ТШЗ, өгөгдлийн хүснэгтэд заасан шаардлага, шалгуур үзүүлэлт, гэрээний нөхцөл, тендерийн жишиг маягт, техникийн тодорхойлолт болон тэдгээрт иш татсан хууль, журам, зааврыг судалж, түүнд өөрчлөлт оруулсан бол өөрчлөлтөд нийцүүлэн тендер бэлтгэнэ.
- 10. Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах**
- 10.1. Сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичигт заасан асуудлаар тодруулга авах шаардлагатай бол энэ тухай хүсэлтийг хуулийн 19 дүгээр зүйлд зааснаар захиалагчид гаргах бол Өгөгдлийн хүснэгтэд заасан хаягаар хүргүүлнэ.
- 10.2. ТШЗ 10.1-д заасан хүсэлтэд ТШЗ-ны 6.4-т заасан сонирхогч этгээд болохыг нотлох баримтыг хавсаргана.
- 10.3. Тодруулгын дагуу тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл захиалагч хуулийн 20.6-д заасны дагуу шийдвэрлэнэ.
- 11. Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт**
- 11.1. Хуулийн 19.4-т зааснаар уулзалт зохион байгуулах, эсхүл ажлын талбайтай танилцуулах бол өгөгдлийн хүснэгтэд заана. Захиалагч уулзалтад ТШЗ-ны 6.6-д заасан сонирхогч этгээд, түүний төлөөллийг оролцуулна.
- 11.2. ТШЗ-ны 11.1-д заасан уулзалтад оролцоогүй нь аж ахуй эрхлэгчийн тендер шалгаруулалтад оролцох эрхийг хязгаарлах үндэслэл болохгүй.
- B. ТЕНДЕР БЭЛТГЭХ**
- 12. Тендер шалгаруулалтын баримт бичгийн болон тендерийн хэл**
- 12.1. Тендер шалгаруулалтын зарлал, баримт бичиг, урилгыг гадаад хэлээр давхар нийтэлсэн эсэхээс үл хамааран тендер шалгаруулалтын баримт бичиг, тендер шалгаруулалттай холбогдох албан бичиг, захидал, бусад баримт бичиг, оролцогчийн ирүүлэх тендер монгол хэлээр байх ба өөр хэлээр үйлдсэн тендер, түүний доторх баримт бичиг, мэдээллийг орчуулсан орчуулгыг тендерт оролцогч бэлтгэн ирүүлнэ.
- 12.2. Зөвхөн гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусlamжийн хөрөнгөөр санхүүжүүлэх бараа худалдан авах тендер шалгаруулалтын хувьд Монгол Улсын олон улсын гэрээг үндэслэн ТШЗ-ны 12.1-д заасан хэлийг өгөгдлийн хүснэгтэд өөрөөр зааж болно.
- 12.3. Тендер шалгаруулалтын баримт бичгийн хэл болон гадаад хэлээрх хувилбар хоорондоо зэрвэл ТШЗ-ны 12.1-д заасан хэлээр бэлтгэсэн тендер шалгаруулалтын баримт бичгийг баримтална.
- 12.4. Захиалагч ТШЗ-ны 12.1-д зааснаас өөр хэлээр үйлдсэн баримт бичгийн орчуулгыг тендер хянан үзэх, үнэлэхэд ашиглах ба оролцогч өөрөө орчуулсан, эсхүл бусад этгээд орчуулсан эсэхээс үл хамааран үнэн зөв, зөрүүгүй болохыг захиалагчийн өмнө хариуцна.

- 13. Тендерийн иж бүрдэл**
- 13.1. Тендер нь хуулийн 21.1-д нийцүүлж бэлтгэсэн бараа нийлүүлэх техникийн болон үнийн санал байна.
 - 13.2. Оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер дараах баримт бичиг, мэдээллээс бүрдэнэ:
 - 13.2.1. ТШЗ-ны 14 дүгээр зүйлд заасны дагуу бэлтгэсэн маягтууд;
 - 13.2.2. оролцогчийн итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдээс өөр этгээд тендерийг баталгаажуулсан бол холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн олгосон итгэмжлэл /гадаадын этгээдийн хувьд итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг нотлох баримт/;
 - 13.2.3. захиалагч зөвшөөрсөн бол ТШЗ-ны 15 дугаар зүйлд заасны дагуу бэлтгэсэн хувилбарт санал;
 - 13.2.4. оролцогч ТШЗ-ны 16 дугаар зүйлд заасан ерөнхий шаардлагыг хангасан болохыг нотлох баримт бичиг;
 - 13.2.5. санал болгож буй бараа ТШЗ-ны 17 дугаар зүйлд заасан тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг;
 - 13.2.6. бараа нийлүүлэлтийн хуваарь;
 - 13.2.7. тендерт оролцогчийн чадавх, туршлага ТШЗ-ны 18, ТШЗ 19, ТШЗ 20 дугаар зүйлд заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангахыг нотлох баримт бичиг;
 - 13.2.8. ТШЗ-ны 21 дүгээр зүйлд заасан барааны үнийн задаргаа;
 - 13.2.9. ТШЗ-ны 21.9-д заасан тохиолдолд холбогдох тайлбар;
 - 13.2.10. түншлэл бол хуулийн 6.3-т заасан түншлэлийн гэрээ.
 - 13.3. Оролцогч өөрийн тендерийн бүх баримт бичиг, мэдээллийн хүчинтэй байдлыг нягтлах үүрэгтэй бөгөөд үнэн зөвийг захиалагчийн өмнө хариуцна.
 - 13.4. Оролцогч хуулийн 22.7, 22.10-т заасныг үндэслэн тендерийн баталгаа хүргүүлж, үйлчилгээний хураамж төлснөөр тендер илгээнэ.
- 14. Тендерийн жишиг маягтууд**
- 14.1. Оролцогч нь тендер шалгаруулалтын баримт бичгийн V бүлэг дэх маягтын мэдээллийг хуулийн 21.1.3-т зааснаар цахим системд үүсгэсэн маягтын дагуу илгээнэ.
- 15. Хувилбарт санал**
- 15.1. Өгөгдлийн хүснэгтэд тусгайлан заасан тохиолдолд оролцогч хуулийн 11.10-т заасанд нийцэх хувилбарт саналыг тендерт ирүүлж болно.
 - 16.1. Оролцогч хуулийн 7.2-т заасан мэдэгдлийг V бүлгийн Маягт 1-ийн дагуу ирүүлнэ.

- 16. Ерөнхий шаардлагыг магадлахад шаардлагатай баримт бичиг**
- 16.2. Монгол Улсын хуулийн этгээд нь шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа явагдаж байгаа эсэх талаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тодорхойлолтыг ирүүлнэ.
- 16.3. Гадаадын этгээд нь үүсгэн байгуулагдсан, эсхүл оршин суугаа улсын төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан дараах баримт бичиг, эсхүл түүнтэй адилтгах баримт бичгийг ирүүлнэ:
- 16.3.1. хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ, түүнийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг тодорхойлох баримт бичиг;
- 16.3.2. гадаадын иргэн, харьяалалгүй хүн бол паспорт, түүнийг орлох баримт бичиг;
- 16.3.3. тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар тухайн улсын хуулиар татварын хугацаа хэтэрсэн өргүй болохыг нотлох баримт бичиг.
- 16.4. Захиалагч оролцогчийн ерөнхий нөхцөлийг магадлах зорилгоор зөвхөн ТШЗ-ны 14.2, 14.3-т заасан баримт бичгээс бусад баримт бичгийг ирүүлэхийг оролцогчоос шаардахгүй ба шаардлагатай бусад нөхцөлийг оролцогчийн ирүүлсэн мэдэгдэл, хуулийн 15.2-т заасан мэдээлэлд үндэслэн магадлна.
- 17. Санал болгож буй бараа тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг**
- 17.1. Нийлүүлэхээр санал болгох барааны гарал үүслийн мэдээллийг V бүлгийн 0-ын холбогдох хэсэгт бөглөж ирүүлнэ.
- 17.2. Хууль тогтоомжоор барааны гарал үүслийг заавал нотлохоос бусад тохиолдолд импортын барааны гарал үүслийг нотлох баримт бичиг тендерт ирүүлэхийг шаардахгүй.
- 17.3. Оролцогчийн санал болгож буй бараа нь III бүлэгт заасан техникийн тодорхойлолтод нийцсэнийг нотлох баримтыг өгөгдлийн хүснэгтэд зааснаар тендерт ирүүлнэ.
- 17.4. Өгөгдлийн хүснэгтэд заасан бол оролцогч өөрийн санал болгож байгаа бараанд холбогдох загвар, дээжийг тендер нээх эцсийн хугацаанаас өмнө захиалагчид хүргүүлэх ба шалгалт, туршилтыг хийх ажиллагаанд оролцогчийг өгөгдлийн хүснэгтэд зааснаар оролцуулна.
- 17.5. Нотлох баримт нь нийтлэл, зураг, үйлдвэрлэгчийн албан ёсны цахим хуудас хэлбэрээр байж болно. Санал болгох бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэнийг харуулах зорилгоор тэдгээрийн техникийн болон гүйцэтгэлийн бодит үзүүлэлтийг техникийн тодорхойлолттой нийцсэн болохыг хянан үзэх боломжтой баримт, хэрэв санал болгох бараа техникийн тодорхойлолтын аль нэг зүйлээс зөрүүтэй, орхигдуулсан бол энэ тухай тайлбарласан тайлбар ирүүлсэн байна.

- 17.6. Барааг нийлүүлснээс хойш өгөгдлийн хүснэгтэд заасан хугацааны туршид тасралтгүй, горимын дагуу ашиглахад шаардагдах өгөгдлийн хүснэгтэд заасан сэлбэг хэрэгсэл, тусгай багаж болон бусад зүйлсийн жагсаалтыг тэдгээрийг авах боломжтой хаяг, үнийн мэдээллийн хамт ирүүлнэ.
- 17.7. Техникийн тодорхойлолтод дурдсан чанар, материал, тоног төхөөрөмжийн загвар, хэмжих нэгж, стандарт, барааны тэмдэг, каталогийн дугаар зэрэг нь тухайн бараанд тавигдах үндсэн шаардлагыг тодорхойлох бөгөөд үүгээр хязгаарлагдахгүй.
- 17.8. Гадаадын этгээдийн хувьд гэрээний дагуу хийгдэх техникийн тодорхойлолтод заасан нийлүүлэлтийн дараах засвар, үйлчилгээг үзүүлэх үүргийг Монгол Улсын нутаг дэвсгэрт өөрөө, эсхүл өөрийн Монгол Улсад байгуулсан буюу байгуулах салбар, төлөөний газар, эсхүл бусад төлөөлөгч гүйцэтгэх тухай баримт;
- 17.9. Монгол Улсын гарал үүсэлтэй бус бараа нийлүүлэхээр санал болгосон оролцогч нь техникийн тодорхойлолтод заасан нийлүүлэлтийн дараах засвар, үйлчилгээг хэрхэн үзүүлэх тухай баримт болон мэдээлэл;
- 17.10. Хуулийн 8.4-т зааснаар давуу эрх тооцуулах барааны Монгол Улсын гарал үүсэлтэй болохыг нотлох баримт бичгийг тендерт ирүүлснээр Сангийн сайдын баталсан Давуу эрх олгох аргачлал, зааврын дагуу тооцно. Барааны үнийн задаргаанд Монгол Улсын гарал үүсэлтэй болохыг заагаагүй, эсхүл гарал үүслийг нотлох баримт ирүүлээгүй тохиолдолд давуу эрх тооцохгүй.
- 17.11. ТШЗ-ны 1.3-т зааснаар нийлүүлэхээр санал болгох бараа Монгол Улсын гарал үүсэлтэй болохыг нотлох баримт бичгийг тендерт ирүүлнэ. Нотлох баримт бичиг ирүүлээгүй тохиолдолд тухайн барааг шаардлага хангаагүй гэж үзнэ.
- 17.12. Тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдээс нийлүүлэхээр санал болгосон бол шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.

18. Чадавхын туршлагын шаардлага

- болон
- 18.1. Захиалагч санхүүгийн болон техникийн чадавх, туршлагын талаар хангавал зохих доод шаардлага, шалгуур үзүүлэлтийг өгөгдлийн хүснэгтэд заах ба хуулийн 15 дугаар зүйлд заасныг баримтална.
 - 18.2. Бараа нийлүүлэх, дагалдах үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай зөвшөөрөл, эсхүл гэрчилгээ байгаа бол өгөгдлийн хүснэгтэд заана. Тухайн бараа, дагалдах үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай нэг зөвшөөрөл, эсхүл гэрчилгээг захиалагч шаардсан бол түншлэлийн гишүүн тус бүр уг шаардлагыг хангасан байх шаардлагатай. Хэд хэдэн зөвшөөрөл, гэрчилгээ шаардсан бол түншлэлийн гишүүд хамтдаа бүрэн хангасан байна.

- 18.3. Түншлэл нь ТШЗ-ны 18.1-д заасан доод шаардлага, шалгуур үзүүлэлтийг гишүүдийн тооноос үл хамааран хамтдаа бүрэн хангасан байна. Борлуулалтын орлогын хэмжээ, ижил төстэй гэрээний үнийн дүнгийн шалгуур үзүүлэлтийг ТШЗ-ны 18.1-д заасан бол төлөөлөх эрх бүхий гишүүн уг шалгуур үзүүлэлтийн 40 ба түүнээс дээш хувийг, түншлэлийн гишүүн тус бүр 25 ба түүнээс дээш хувийг хангасан байна.
- 18.4. Туслан гүйцэтгэгч нь энэ зүйлд заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийн өөрт холбогдох хэсгийг хангаж байгааг нотлох баримт бичгийг тендert ирүүлнэ.
- 19. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт**
- 19.1. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 16.2, 16.4-т заасан баримт бичгээс сонгож өгөгдлийн хүснэгтэд заана. Оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох санхүүгийн тайлангийн хугацааг өгөгдлийн хүснэгтэд заана.
- 19.2. Оролцогчийн дансны мэдээлэл, түүний үлдэгдлийн талаар харилцагч банкнаас мэдэгдсэнээс бусад банк, санхүүгийн байгууллагын мэдэгдлийг оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд харгалзан үзэхгүй. Захиалагч энд зааснаас бусад асуудлаар харилцагч банкны тодорхойлолт ирүүлэхийг шаардахгүй.
- 19.3. Монгол Улсын хуулийн этгээдийн банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх талаар лавлагааг Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан этгээдээс цахим системээр авч, тендert ирүүлэх ба уг асуудлаар банк, санхүүгийн байгууллагаас лавлагаа ирүүлэхийг шаардахгүй.
- 20. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт**
- 20.1. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 17.2.2, 17.2.3, 17.2.4, 17.2.5-д заасан баримт бичгээс сонгож өгөгдлийн хүснэгтэд заана.
- 21. Тендерийн үнэ ба үнийн хөнгөлөлт**
- 21.1. Оролцогчийн санал болгож буй үнэ, үнийн хөнгөлөлт нь энэ зүйлд заасан шаардлагад нийцсэн байна.
- 21.2. Барааны үнийн задаргаанд багц тус бүрийн барааны нэр төрөл тус бүрээр нэгж болон нийт үнийг тусгаж ирүүлнэ.
- 21.3. Оролцогч үнийн хөнгөлөлт санал болгох бол ТШЗ-ны 14-т заасан тендер илгээх маягтад заана.
- 21.4. ТШЗ 21.3-т зааснаар үнийн хөнгөлөлт тооцсоны дараах үнийг тендерийн үнэ гэж үзнэ.

- 21.5. Хууль болон өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол оролцогчийн санал болгосон үнэ нь гэрээний хэрэгжилтийн явцад тогтмол байх бөгөөд тохируулга хийхгүй. Тохируулга хийх нөхцөлтэй үнэ санал болгосон тендерийг шаардлага хангаагүй гэж үзнэ. Өгөгдлийн хүснэгтэд үнийн тохируулга хийхийг зөвшөөрсөн тендер шалгаруулалтад тогтмол үнэ санал болгосон тендер ирүүлсэн нь тендерээс татгалзах үндэслэл болохгүй ба үнийн тохируулга нь гэрээний хэрэгжилтийн явцад тэгтэй тэнцүү гэж үзнэ.
- 21.6. Бараа нийлүүлэх тендерт Олон улсын худалдааны танхимаас эрхлэн гаргадаг Олон улсын худалдааны нөхцөл /Incoterms-/ийг хэрэглэхдээ өгөгдлийн хүснэгтэд заагаагүй бол хамгийн сүүлийн хувилбарын Delivery Duty Paid /DDP/ нөхцөлийг бараа нийлүүлэлтийн хуваарьт дурдсан газарт хүргүүлэхээр хэрэглэнэ.
- 21.7. Үнийн задаргаанд тусгайлан тусгасан эсэхээс үл хамааран тендерийн үнэд хуулийн 27.13-т заасан зардлыг багтсанд тооцно.
- 21.8. ТШЗ-ны 21.2-т заасан барааны үнийн задаргааны нийт нийлбэр нь арифметик алдаагүй боловч тендер илгээх маягтад үнээс зөрүүтэй бол барааны үнийн задаргааны нийт нийлбэрийг тендер илгээх маягтын үнэ гэж үзнэ.
- 21.9. Хуулийн 21.5-д заасан тохиолдолд тендер шалгаруулалтын оролцогчийн тендерийн үнэ төсөвт өртгийн 80 хувиас доош бол уг үнэ нь бараа, ажил, үйлчилгээний хамрах хүрээ, чанар болон гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлэхгүй талаар үндэслэл бүхий тайлбарыг тендерт ирүүлнэ.

22. Тендерийн валют

- 22.1. Монгол Улсын олон улсын гэрээ болон хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол тендерийн үнийг Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4.1, 4.2-т заасны дагуу үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэхээр заана.

23. Тендер хүчинтэй байх хугацаа

- 23.1. Оролцогч хуулийн 21.1.1-д заасны дагуу тендер нээснээс хойш өөрийн тендер хүчинтэй байх хугацааг ажлын 30-аас багагүй өдөр байхаар тендер илгээх маягтад заана.
- 23.2. Оролцогч тендерийн хүчинтэй байх хугацааг сунгасан бол ТШЗ-ны 24-т заасан тендерийн баталгааны хүчинтэй байх хугацаа мөн адил тендерийн баталгааны нөхцөлийн дагуу сунгагдахыг баталгаа гаргагч болон оролцогч хариуцна.
- 23.3. Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж буй тохиолдолд оролцогчийн тендерийн хүчинтэй байх хугацаа нь худалдан авах барааны санхүүжилтийн эх үүсвэр батлагдсаны дараа гэрээ байгуулах хүртэл хугацаанд хүчинтэй байхаар заана.

- 24. Тендерийн баталгаа**
- 24.1. Захиалагч хуулийн 14.1-д заасан тохиолдолд төсөвт өртгийн 0.5 хувиар тооцсон “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцсэн тендерийн баталгаа ирүүлэхийг өгөгдлийн хүснэгтэд заана.
 - 24.2. Тендер шалгаруулалтыг багцад хуваасан бол тендерийн баталгааг багц тус бүрээр ТШЗ-ны 24.1-д зааснаар ирүүлнэ.
 - 24.3. Түншлэлийн хувьд түүнийг төлөөлөх эрх бүхий гишүүн тендерийн баталгааг ирүүлнэ.
- Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ**
- 25. Тендер баталгаажуулах, илгээх**
- 25.1. Тендерийг хуулийн 22.1-д зааснаар баталгаажуулан, тендерийн баталгаа шаардсан тохиолдолд тендерийн баталгааг ТШЗ 24-т зааснаар илгээнэ.
 - 25.2. ТШЗ-ны 25.1-д заасны дагуу баталгаажуулсан этгээд оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд бол итгэмжлэл ирүүлэх шаардлагагүй.
 - 25.3. Оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд тендерийг тоон гарын үсгээр баталгаажуулсан бол V бүлэгт заасан маягтыг ТШЗ-ны 25.1-д зааснаар тамга, тэмдгээр баталгаажуулсан гэж үзнэ. Энэ тохиолдолд маягтыг баталгаажуулахтай холбоотой итгэмжлэл үйлдэх, хуулийн этгээдийн тамга, тэмдгээр баталгаажуулахыг шаардахгүй.
 - 25.4. Оролцогч хуулийн 22.5-д заасан хүний эмзэг мэдээлэлд хамаарах мэдээллийг ил болгохгүйгээр илгээх бол хуулийн 22.6.3-т заасан мэдэгдлийг V бүлгийн Маягт 6-ын дагуу нууцлахгүйгээр ирүүлнэ.
 - 25.5. Хуулийн 22.6-д заасан баримт бичиг, мэдээллийг заавал ил болгож илгээх ба ТШЗ-ны 25.4-т заасан нь уг баримт бичгүүдэд хамаарахгүй. Захиалагч тухайн тендер шалгаруулалтад нэмэлтээр ил болгох баримт бичгийг өгөгдлийн хүснэгтэд заах ба уг баримт бичиг хүний эмзэг мэдээлэл хамаарах бол мэдээллийн эзний зөвшөөрлийг авсны үндсэн дээр тендер илгээнэ.
- 26. Тендер хүлээн авах эцсийн хугацаа**
- 26.1. Тендер хүлээн авах эцсийн хугацааг өгөгдлийн хүснэгтэд заана. Огноо, цагийг цахим системийн серверийн цагаар тооцно.
 - 26.2. Захиалагч тендерийн нээлтийг цахим системээр өгөгдлийн хүснэгтэд заасан огноо, цагт зохион байгуулна. Тендерийн нээлтэд оролцогч, эсхүл түүний төлөөлөгч байлцах эрхтэй.
- Д. ЗАХИАЛАГЧ ШИЙДВЭР ГАРГАХ**
- 27. Тендерийн талаар тодруулга авах**
- 27.1. Захиалагч тендерийн талаар тодруулга авах тохиолдолд хуулийн 25 дугаар зүйлд заасан журмыг баримтална.

28. Тендерийг шаардлагад нийцсэн эсэхийг хянан үзэх	28.1. Тендерийг хянан үзэхэд хуулийн 26 дугаар зүйлд заасан журам ТШЗ-ны 14 дүгээр зүйлд заасан иж бүрдэл, холбогдох мэдээллийн сангаас илгээсэн мэдээлэл, оролцогч болон түүний тендерийн талаар авсан тайлбар, тодруулга, загвар, дээжид үндэслэн хянан үзнэ.
29. Тендерийг үнэлэх	29.1. Захиалагч тендерийг хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу үнэлж, харьцуулна. 29.2. Өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол тендер үнэлэх үндсэн шалгуур нь харьцуулах үнэ байна.
30. Арифметик алдааг залруулах	30.1. Тендерийн үнийн арифметик алдааг “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-т зааснаар залруулна. 30.2. ТШЗ-ны 30.1-д заасны дагуу арифметик алдааг залруулсан тухай мэдээллийг оролцогчид хүргүүлнэ.
31. Давуу эрх олгох	31.1. Захиалагч нь өгөгдлийн хүснэгтэд заасан мэдээлэл, баримт бичгийг ирүүлсэн дотоодын бараанд хуулийн 8.4-т зааснаар давуу эрх олгож, дотоодын барааны хэсгийн үнийг хууль болон холбогдох аргачлал, зааврын дагуу хийсвэрээр бууруулж тооцно. 31.2. ТШЗ-ны 31.1-д заасан нотлох баримт ирүүлээгүй тохиолдолд давуу эрх олгохгүй ба энэ нь тухайн оролцогчийн ирүүлсэн тендерээс татгалзах үндэслэл болохгүй. 31.3. Давуу эрх авч гэрээ байгуулсан гүйцэтгэгч гэрээний үүрэг гүйцэтгэхэд давуу эрх тооцуулсан нөхцөлийг биелүүлээгүй нь тендер шалгаруулалтад оролцох эрх хязгаарлах нөхцөл болохыг анхаарах шаардлагатай.
32. Үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт	32.1. Өгөгдлийн хүснэгтэд заасан бол IV бүлэгт заасан үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг мөнгөөр илэрхийлж, харьцуулах үнийг хийсвэрээр нэмэгдүүлнэ.
33. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлох	33.1. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлоход “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-ыг баримтална. 33.2. ТШЗ-ны 15.1-д зөвшөөрсний дагуу хувилбарт санал ирүүлсэн тендер “хамгийн сайн” гэж үнэлэгдсэн бол түүний хувилбарт саналыг үндсэн тендерийн нэгэн адил хянан үзэж, үнэлнэ. 33.3. ТШЗ-ны 33.2-т зааснаар тендерийн саналын хувилбарыг хянан үзэх, үнэлэхэд үндсэн тендерийг үнэлсэн журмыг баримтална.
34. Тендерийг эрэмбэлэх	34.1. Захиалагч тендеруудийг эрэмбэлэхэд хуулийн 27.5, 27.6-д заасныг баримтална.
35. Оролцогчийн чадавхыг дахин магадлах	35.1. Захиалагч хэд хэдэн багцад хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчийг тэдгээр багцад заасан гэрээний үүрэг гүйцэтгэх чадавхтай эсэхийг дахин магадлна.

- 35.2. ТШЗ-ны 35.1-д заасны дагуу дахин магадлахад зөвхөн ТШЗ-ны 19 дугаар зүйлд заасан санхүүгийн чадавх, ТШЗ-ны 20 дугаар зүйлд заасан техникийн чадавх, туршлагын талаар шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангах эсэхийг тендер хянан үзэхэд ашигласан баримт бичиг, мэдээлэлд үндэслэнэ.
- 35.3. ТШЗ-ны 35.2-т заасны дагуу оролцогчийн чадавхыг дахин магадалж, хуулийн 27.10-т зааснаар гэрээ байгуулах эрх олгоно.

Е. ШИЙДВЭР ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ

- | | |
|---|--|
| 36. Шийдвэр хүргүүлэх | 36.1. Захиалагч хуулийн 28 дугаар зүйлд заасан шийдвэр гаргаж, оролцогчдод мэдэгдэнэ. |
| 37. Гүйцэтгэлийн баталгаа | 37.1. Хуулийн 42.1-д заасан тохиолдолд гэрээ байгуулах эрх авсан оролцогч тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн гурван хувийн үнийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ.
37.2. Гүйцэтгэлийн баталгааг “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцүүлэн гаргана. |
| 38. Гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах | 38.1. Захиалагч ТШЗ-ны 9.2-т заасан гэрээний нөхцөлийн гэрээ баталгаажуулах маягтыг түүнд заасан зааврын дагуу шаардлагатай хэсгийг эцэслэн нөхөж, оролцогчид хүргүүлнэ.
38.2. Шалгарсан оролцогч ТШЗ-ны 38.1-д зааснаар ирүүлсэн гэрээнд гарын үсэг зурж, баталгаажуулан захиалагчаас шаардсан хугацааны дотор хүргүүлнэ. |

II БҮЛЭГ. ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ (ӨХ)

А. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ	
ТШЗ-ны холбогдох заалт	
ТШЗ 1.1	Захиалагч: “ <i>Тавантолгой түлш</i> ” ХХК
ТШЗ 1.1	Тендер шалгаруулалтын нэр: “ Холбоо дохиолол камержуулалт худалдан авах ”
ТШЗ 1.1	Тендерийн урилгын дугаар: “ TTTXXK/20240102166 ”
ТШЗ 1.2	Тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: “ Багцгүй ”
ТШЗ 1.4	Тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа эсэх: “ Үгүй ”
ТШЗ 2.1	Санхүүжилтийн эх үүсвэр нь: “ Өөрийн хөрөнгөөр ”
ТШЗ 2.1	Нийт төсөвт өртөг: 905,000,000 (Есөн зуун таван сая) төгрөг
Б. АГУУЛГА	
ТШЗ 8.1	<p>Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах хүсэлтийг захиалагчид хүргүүлэх хаяг:</p> <p>Хаяг: Төв аймаг, Сэргэлэн сум, 1-р баг, Баянбүрд, Баян уулын баруун талд 0 тоот</p> <p>Утасны дугаар: 70119400</p> <p>Цахим шуудангийн хаяг: info@ttt.mn</p>
ТШЗ 11.1	Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт зохион байгуулах эсэх: “ Үгүй ”
В. ТЕНДЕР БЭЛТГЭХ	
ТШЗ 12.1	Тендер шалгаруулалтын хэл: “ Монгол хэл ” Тендер шалгаруулалтын зарлал, баримт бичиг, урилгыг гадаад хэлээр давхар нийтэлсэн эсэхээс үл хамааран тендер шалгаруулалтын баримт бичиг, тендер шалгаруулалттай холбогдох албан бичиг, захидал, бусад баримт бичиг, оролцогчийн ирүүлэх тендер монгол хэлээр байх ба өөр хэлээр үйлдсэн тендер, түүний доторх баримт бичиг, мэдээллийг орчуулсан орчуулгыг тендерт оролцогч бэлтгэн ирүүлнэ.
ТШЗ 15.1	Хувилбарт санал ирүүлэхийг: “ Зөвшөөрөхгүй ”
ТШЗ 16.2	<p>Ерөнхий шаардлагыг магадлахад шаардлагатай баримт бичиг:</p> <p>Монгол Улсын, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу өр төлбөр төлүүлэх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагдаж байгаа, эсхүл татварын, эсхүл нийгмийн даатгалын шимтгэлийн хугацаа хэтэрсэн өртэй бол ерөнхий шаардлага хангахгүй гэж үзнэ.</p> <p>Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбарыг ирүүлэх шаардлагагүй бөгөөд “Төрийн мэдээлэл солилцооны ХҮР систем”-ээр дамжуулан шалгана.</p> <p>Үйл ажиллагааны чиглэл нь хяналтын камер сууринуулах чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг байна.</p>

	<p>Монгол Улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө тухайн тендер нээсэн өдрийн байдлаар бүрэн төлсөн, өр төлбөргүй байх шаардлагатай. Шүүхийн өр төлбөргүй тодорхойлолт, Нийгмийн даатгал, татварын тодорхойлолтыг ирүүлэхдээ “Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем ”www.tender.gov.mn болон“ Төрийн мэдээлэл солилцооны ХУР систем”-ээр дамжуулан Татварын өрөнхий газар, Нийгмийн даатгалын өрөнхий газрын цахим мэдээллийн сангаас шалгана</p>			
ТШЗ 17.4	Тендер нээх эцсийн хугацаанаас өмнө загвар, дээж ирүүлэх эсэх: “Үгүй”			
ТШЗ 17.6	Барааны хувьд тасралтгүй, горимын дагуу ажиллуулахад шаардагдах сэлбэг хэрэгсэл, тусгай багаж болон бусад эд зүйлсийн жагсаалт ирүүлэх эсэх, ирүүлэх бол хугацаа: “Үгүй”			
ТШЗ 18.1	Барааг дагалдах үйлчилгээг хэрэгжүүлэх хүний нөөцийн шаардлага, шалгуур үзүүлэлт: “Шаардана”			
№	Албан тушаал	Хүний тоо	Ажлын туршлага/жил/	Боловсрол, мэргэжлийн ур чадвар /мэргэжлүүдийн аль нэгийг эзэмшсэн байх/
1	Ерөнхий инженер	1	10 болон түүнээс дээш жил ажилласан байх	Мэдээлэл технологийн инженер, Холбоо дохиололын инженер, Электроникийн инженер
2	Мэдээлэл технологийн инженер	3	3 болон түүнээс дээш жил ажилласан байх	Мэдээлэл технологийн инженер, Холбоо дохиололын инженер, Электроникийн инженер
3	ХАБ-ын инженер	1	1 болон түүнээс дээш жил ажилласан байх	Сертификаттай байх
3	Туслах ажилтан	2	Гэрээт ажилтан байж болно	Мэдээлэл технологийн инженер, Холбоо дохиололын инженер, Электроникийн инженер
	<p>Дээрх ажилчдын 50-аас доошгүй хувь нь үндсэн ажилтан байх ба мэргэжлийн үнэмлэх дипломын хуулбар тухайн компаниас сүүлийн 3 сар нийгмийн даатгал шимтгэл төлсөн тодорхойлолт ирүүлэх шаардлаггүй бөгөөд төрийн мэдээллийн хур системд оролцогч байгууллага мэдээллээ бэлтгэн илгээсэн байна. /Ажилтаны мэдээлэл цахим системд оруулж илгээгээгүй тохолдолд тухайн тендерээс татгалзах үндэслэл болно/ Гэрээт</p>			

	<p>ажилтан бол хөлсөөр ажиллах гэрээ мэргэжлийн үнэмлэх дипломын хуулбарыг бүрэн баталгаажуулан ирүүлэх.</p> <p>Мэдээлэл технологийн инженер нь олон улсын HSCA-CCTV HSCA-VMS сертификат эсхүл тухайн брендийн сургалтад хамрагдсан сертификатыг эзэмшсэн байна.</p> <p>Дээрх инженер, техникийн ажилтнуудын Сургууль төгссөн дипломын хуулбарыг хавсаргана, “Төрийн мэдээлэл солилцооны ХҮР систем”-ээр дамжуулан Боловсрол, шинжлэх ухааны яамны мэдээллийн сангаас шалгана. “Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (E-Mongolia)-д инженер, техникийн ажилтнуудын дээд боловсролын дипломын мэдээлэл байршсан эсэхийг лавлах шаардлагатай.</p> <p>Дээрх инженер техникийн ажилтны иргэний үнэмлэхийн эхээс хийсэн хуулбар ирүүлнэ.</p> <p>Дээрх мэдээлэл зөрүүтэй бүртгэгдсэн бол тендерийн нээлтээс өмнө БШУЯ-ны Мэдээллийн технологи статистикийн хэлтэст хандаж дээд боловсролын удирдлагын мэдээллийн системд бүртгүүлнэ үү.</p> <p>Ижил төстэй бараа нийлүүлсэн туршлагыг нотлох гэрээний туршлагын шаардлага: “Шаардана”</p> <ol style="list-style-type: none"> <i>Батлагдсан төсөөт өртгийн 50 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй барааг сүүлийн 2 жил буюу 2022, 2023 онуудын аль нэг жилд нийлүүлсэн байх.</i> <i>Ижил төстэй бараа гэдэгт камержуулалт, камериийн тоног төхөөрөмж нийлүүлэх, сууринуулах ажлыг хийж гүйцэтгэсэн байх.</i> <i>Ижил төстэй ажил гүйцэтгэсэн гэрээний мэдээллийг Маягт №3 болон №5 даагуу бэлтгэн ирүүлэх.</i> <p>Бараа нийлүүлэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн шаардлага: “Шаардахгүй”</p>
ТШЗ 18.2	<p>Тусгай зөвшөөрөл: “Шаардана”</p> <ol style="list-style-type: none"> <i>Гадна холбооны кабель шугам, цамхаг түүн дээрх холбооны тоног төхөөрөмж угсралт сууринуулалт, засвар</i>
ТШЗ 19.1	<p>Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг шаардах эсэх: “Тийм”</p> <ol style="list-style-type: none"> <i>Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдээс тендер шалгаруулалт зарласан өдрөөс хойш авсан, шалгах боломжтой QR код бүхий “Зээлийн мэдээллийн сангийн тодорхойлолт”-ыг ирүүлнэ. Уг тодорхойлолтод төлөгддөж дуусаагүй зээлийн мэдээлэл “Хэвийн” бус байгаа тохиолдолд татгалзах үндэслэл болно. (“Зээлийн мэдээллийн сангийн тодорхойлолт”-ыг www.sainscore.mn, www.burenscore.mn хаягаар хандан авна.</i> <i>Санхүүгийн тайланд аудит хийлгэх үүрэгтэй оролцогчийн хувьд аудитын дүгнэлтийг 2022, 2023 он тус бүрээр ирүүлнэ.</i> <i>Сүүлийн 2 жил буюу 2022, 2023 он тус бүрийн борлуулалтын орлого төсөөт өртгийн 100 хувиас багагүй байна.</i> <i>Харилцагч банкнаас хугацаа хэтэрсэн зээл, зээлийн хүүгийн өр, төлбөргүй талаарх тодорхойлолтыг ирүүлэх шаардлаггүй.</i> <p><i>Түргэн хөрөөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийт дунг дараах шалгуур үзүүлэлтүүдийг аль нэгээр эсвэл тэдгээрийн</i></p>

	<p>нийлбэрээр нь тодорхойлно. /Төсөөт өртгийн 60%-аас багагүй байна/ Уүнд:</p> <p>1.1. Байгууллагын харилцагч банкан дахь харилцах дансны үлдэгдлийн баталгаа, /Тендерийн нээлт хийхээс долоо хоног дотор авсан байна/</p> <p>1.2. Арилжааны банкнаас аөч болох мөнгөн дүн бүхий судлагдсан зээлийн тодорхойлолт ирүүлнэ /Тендерийн нээлт хийхээс долоо хоног дотор авсан байна, Тухайн тендерт шалгарсан тохиолдолд зээлийн бодлого, бүтээгдэхүүний журам, шаардлага хангасан нөхцөлд олгох боломжтой зээлийг баталгаажсан эрх гэж үзэхгүй, Зөвхөн олгох боломжтой зээл болон зээлийн шугамыг үнэлгээнд харгалзан үзнэ./</p>
ТШЗ 20.1	<p>Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэх эсэх: “Тийм”</p> <ol style="list-style-type: none"> Гэрээний үүргийн гүйцэтгэлийг хариуцах ажилтны мэдээллийг бэлтгэн ирүүлэх. Оролцогчийн ерөнхий шаардлагыг магадлах ба V бүлгийн Маягт 1-ийн дагуу бэлтгэн ирүүлнэ. Нийлүүлэх барааны үйлдвэрлэгчийн итгэмжлэх буюу үйлдвэрлэгчтэй хийсэн гэрээ эсвэл гэрээт борлуулагч /дистрибутор/ итгэмжлэх бичиг ирүүлэх./Сүлжээний кабель дээр ирүүлэх шаардлагагүй/ Бараа нийлүүлсэн туршлагын мэдээлэл сүүлийн 2 жилээр ирүүлэх (2022, 2023 он) Сүүлийн 2 жилийн аль нэг жилд батлагдсан төсөөт өртгийн үнийн дүнгийн 100%-иас багагүй хэмжээний мэдээлэл технологийн тоног төхөөрөмж, камер нийлүүлэх, сууринуулах ажлыг гүйцэтгэсэн байх. Гэрээ, гэрээ дүгнэсэн акт ирүүлэх. Одоо хэрэгжүүлж байгаа гэрээний мэдээлэл Маягт №4 дагуу ирүүлэх. Мэргэжлийн төсөөвчнөөр төсөөвийг тооцож баталгаажуулан ирүүлэх. Захиалагч болон нийлүүлэгчийн техникийн тодорхойлолтыг харьцуулсан байдлаар хүснэгтээр зураг оруулан бэлтгэн баталгаажуулан ирүүлэх ба техникийн тодорхойлолтод нийцсэн эсэхийг нийлүүлэгч тодорхой тусгаж ирүүлнэ. Чанарын шаардлага хангагүй бараа бүтээгдэхүүнийг өөрийн зардлаар нөхөн ажлын 30 хоногийн дотор нийлүүлэхийг зөвшөөрсөн албан тоот ирүүлэх. Ажлын даалгаварт орсон үйлдвэрийн бүсэд одоо ашиглагдаж байгаа шинээр сууринуулах камераудыг өнгөөр ялгаж инженер техникийн ажилчидтай хамтран ажлын зураг гаргасан байх. Ажлын даалгаварт оруулсан зүйл заалт бүрийг хангаж ажиллах талаар нэг бүрчлэн дугаарласан ажлын даалгаврыг хүлээн зөвшөөрсөн зүйл заалт бүрээр хангаж ажиллах талаар тодорхой тусгаж ирүүлэх. Тухайн тендерт шалгарсан тохиолдолд ажлын даалгаварт ирүүлсэн зүйлс хангаж ажиллах талаар албан бичиг ирүүлэх. /Ажлын даалгавартай танилцах/ Теле хяналтын системд ашиглаж байгаа техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн баталгаат хугацаа 1 жилээс багагүй байх, засвар үйлчилгээний баталгаат хугацаа 1 жил байх.
ТШЗ 21.5.	Оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад: “Тохирнуулахгүй тогтмол байна”

ТШЗ 21.6	Олон улсын худалдааны нөхцөлийг хэрэглэх эсэх: “ Тийм ” <i>Incoterms 2020, Delivery Duty Paid (DDP)</i> “ Тавантолгой түлш ХХК-ийн Төвийн үйлдвэрийн агуулах ”
ТШЗ 24.1	Тендерийн баталгааны дүн: “ Төсөөт өртгийн 0,5 хувиар тооцон ирүүлсэн байх ”
Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ	
ТШЗ 25.5.	Оролцогчдод ил болох баримт бичгийн жагсаалт: “ Шаардлагтай ” <ol style="list-style-type: none"> 1. Оролцогчийн ерөнхий шаардлагыг магадлах нотлох баримт бичиг 2. Үйлдвэрлэгч, борлуулагчтай хийсэн гэрээ эсхүл албан бичиг 3. Тендер шалгаруулалтын баримт бичигт тусгасан маягтын дагуу илгээсэн мэдээлэлүүд 4. Хуулийн 22.5-д заасан үндэслэлээр ил болгохгүй мэдээлэл баримт бичиг, мэдээлэл байгаа бол түүний хууль зүйн үндэслэлийг тайлбарласан мэдээгэл ирүүлэх
ТШЗ 26.1.	Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь: Огноо: 2024 оны 09-р сарын 06-ны өдөр Цаг: 10 цаг 00 минут
ТШЗ 26.2.	Тендерийн нээлтийг доор дурдсан хугацаанд цахим системээр хийх бөгөөд нээлтийн мэдээллийг оролцогч цахим системээр хүлээн авна. Огноо: 2024 оны 09-р сарын 06-ны өдөр Цаг: 10 цаг 30 минут Тендер нээх газрын хаяг: Төв аймаг, Сэргэлэн сум 1-р баg, Баянбуурд, Баян уулын баруун тал, Зүүн үйлдвэр А байрны 231 тоот
Д. ЗАХИАЛАГЧ ШИЙДВЭР ГАРГАХ	
ТШЗ 29.2.	Тендер үнэлэх үндсэн шалгуурыг харьцуулах үнээс өөрөөр тогтоох эсэх: “ Үгүй ”
ТШЗ 31.1.	Давуу эрх тооцуулахад шаардлагатай мэдээлэл, баримт бичиг: “ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль ”-ийн 8-р зүйлийн 8.4-т заасан нөхцөлийн аль нэгийг хангасан тохиолдолд тооцно.
ТШЗ 32.1	Үнэлгээнд харгалзах нэмэлт шалгуур үзүүлэлт ашиглах эсэх: “ Ашиглахгүй ”

III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

“ТАВАНТОЛГОЙ ТУЛШ” ХХК -ИЙН ҮЙЛДВЭРИЙН ОРЧНЫ ХЯНАЛТЫН КАМЕРЖУУЛАЛТЫН НЭГДСЭН СИСТЕМ БИЙ БОЛГОХ ТЕНДЕРИЙН АЖЛЫН ДААЛГАВАР

Үйлдвэр барилга, байгууламжийг камержуулах зорилго.	“Тавантолгой тулш” ХХК-ийн үйлдвэрийн барилга байгууламжийн гадна болон доторх орчин тоноглолууд, гадна талбай орчныг дулаан дөл утаа температур хөдөлгөөн мэдрэгчтэй хяналтын камеруудаар тоноглолуудыг харах, хянах зорилгоор хяналтын камер суурилуулах, тохиргоо үйлчилгээ хийх, диспетчерийн өрөөнд нэгдсэн систем дээр харуулах ажлыг гүйцэтгэнэ.
Үйлдвэр барилга, байгууламжийг камержуулах үндэслэл.	Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 18 дугаар тэмдэглэлийн “Сайжруулсан шахмал түлшний үйлдвэр байгуулах тухай” шийдвэр, “Нийслэл Улаанбаатар хотын зүүн бүсэд сайжруулсан шахмал түлшний үйлдвэр барьж ашиглалтад оруулах” тухай Монгол улсын Засгийн газрын 2020 оны 01 дүгээр сарын 29 -ний өдрийн 35 дугаар тогтоол.
Үйлдвэр барилга, байгууламжийг камержуулах байршил.	“Тавантолгой тулш” ХХК-ийн Зүүн бүсийн үйлдвэр
Үйлдвэр барилга, байгууламжийг камержуулах зураг, төсвийн ерөнхий шаардлага	<ol style="list-style-type: none"> 1. Үйлдвэрийн бүсэд одоо ашиглагдаж байгаа шинээр суурилуулах камеруудыг өнгөөр ялгаж инженер техникийн ажилчидтай хамтран ажлын зураг гаргасан байх. 2. Хяналтын камерын дотоод сүлжээ, шилэн кабель болон цахилгаан тэжээлд холбох сүлжээний топологи зураг гаргасан байх. 3. Хяналтын камеруудын цахилгааны тэжээлийг тусд нь татсан байх. Холболтын хайрцаг руу цахилгааны инженертэй зөвшилцөж 24/7 цагаар тасалдахгүй байхаар тооцоолж цахилгааны утсыг хар хоолойнд хийж цахилгаан тэжээлд холбосон байх зураг гаргасан байх. 4. Гүйцэтгэх ажлын төсөвт захиалагчийн техник хяналтын зардал, магадлашгүй ажлын зардал, зураг төсвийн үнэ, тусгасан байна. 5. Компанийн хэмжээнд одоо ашиглаж байгаа камерын судалгаанд үндэслэн мэргэшсэн төсөвчнөөр баталгаажсан материалын түүвэр техникийн тодорхойлолт гаргасан байх.
Үйлдвэр барилга, байгууламжийг камержуулах сүлжээ холболтын ерөнхий шаардлага.	<ol style="list-style-type: none"> 1. “Тавантолгой тулш” ХХК-ийн ашиглагдаж байгаа нийт 500 дулаан, дөл, царай, утаа мэдрэгчтэй камеруудыг Hikcentral эсхүл түүнтэй дүйцэх програм хангамж дээр нэгтгэн харуулсан байх. 2. Hikcentral эсхүл түүнтэй дүйцэх программ хангамжийн лиценз багтсан байх./lifetime/ 3. 72 слотий HIKVISION SAN DS-A81072S 72-slot Single Controller Storage эсхүл түүнтэй дүйцэх төхөөрөмжийг 16tb багтаамжтай 72 ширхэг хатуу диск суурилуулж 60 -дээшгүй хоногоор бичлэгээ хадгалж шинээр энгийн 86 камер шинээр суурилуулах, PTZ 360-ийн 10 камер гадна цамхагт суурилуулах, дулаан утаа дөл, царай таних мэдрэгчтэй 19 камеруудыг гол гарах эрсдэлтэй цэгүүдэд зургийн дагуу суурилуулах голын дохиоллын системтэй холбож гол гарсан үед дохио өгч дэмжин ажиллах боломжтой байх. 4. Одоо ажиллаж байгаа ДИС серверийн өрөөнд хөргөлтийн систем суурилуулсан байх. 5. Hikvision DS-96128NI-I16 128-ch 3U 4K Super NVR эсхүл түүнтэй дүйцэх 128 сувагтай энгийн болон гол дөл утаа царай мэдрэгчтэй зориулалтын 3 ширхэг бичигчийг тус тусын цехэд суурилуулж диспетчерийн өрөөнд нэгдсэн байдлаар гаргасан байх. 6. Угсралт, суурилуулалтын ажлыг Монгол улсын MNS5471:2005 MNS 6588:2016 стандартын дагуу хийж гүйцэтгэнэ. 7. Сүлжээний зангилаа цэгүүд дээр тавигдах 6 хүртэлх камерт Hikvision DS-3E0510HP-E/M 8 Port Gigabit Unmanaged POE Switch x gigabit fiber optical port эсхүл түүнтэй дүйцэх PoE технологи дэмждэг 15% - аас доошгүй нөөц холболттой байх. 8. Сүлжээний зангилаа цэгүүд дээр тавигдах 8-aac дээш камерт Hikvision PoE 24 port + Gigabit 1 Port Uplink + 1 Port SFP Switch DS-

	<p>3E1326P-E/M 24 port эсхүл түүнтэй дүйцэх PoE технологи дэмждэг 15% - аас доошгүй нөөц холболттай байх.</p> <p>9. Хяналтын камерын сүлжээ холболтын барилга байгууламжийн гадна дотор орчинд 100 м хүртэлх урттай зайнд Hikvision эсхүл түүнтэй дүйцэх STP CAT6 төрлийн гадна зориулалтын кабелийг зориулалтын хамгаалалтын хар хоолойнд хийж татсан байх.</p> <p>10. Барилга доторх кабелиудад далдлагч ашиглахдаа тухайн барилгын хийц, онцлог, зохион байгуулалтаас хамаарч хана болон тааз, шаланд суурилуулах. Хана шал таазанд суурилуулсан далдлагч нь эдэлгээ даахуйц /төмөр, сайжруулсан хуванцар/ материалаар хийгдсэн, хана шал таазны өнгөтэй нийцсэн байх. Кабелиудыг цахилгааны холболтын шугамаас багадаа 30 см, газраас 3 метрээс дээш өндөрт, нөөцтэй цэнэглэж, ашиглахад бэлэн болгож татсан байх.</p> <p>11. Сүлжээний зангилаа цэгүүдэд байрлах зориулалтын хайрцаг нь Toten эсхүл түүнтэй дүйцэхүйц 27 юнитын ракыг стандартын дагуу 1, 2, 3 цехүүд ДИС өрөөнд суурилуулсан байх.</p> <p>12. Сүлжээний зангилаа цэгүүдэд байрлах зориулалтын хайрцаг нь Toten эсхүл түүнтэй дүйцэхүйц 6 юнитын ракыг стандартын дагуу байрлуулж хананаас 10 см хөндий бэхэлсэн өрөө, тасалгаанд шалнаас 2 метрээс доошгүй өндөрт газардуулга хийж суурилуулсан байх.</p> <p>13. Кабель татах боломжгүй онцгой байрлалд камер суурилуулах шаардлага гарвал радио долгионы антен Ubiquiti Rocket M5 access point эсхүл түүнтэй дүйцэх NANO STATION ашиглаж болно. Энэ үед радио долгион нь гаднын нөлөөлөлд өртөхөөргүй байхаар тооцоолж суурилуулалт хийсэн байх.</p> <p>14. Хяналтын камерын сүлжээ холболтыг 100м-ээс дээш урт зайнд агаарын эсвэл сувагчлалын 12-өөс доошгүй шөрмөстэй шилэн кабелийг дагалдах төхөөрөмжүүдийн хамт хэрэглэсэн байх. Агаараар татах тохиолдолд уян ган трассонд багцалж, төгсгөлийг газардуулсан холбооны хайрцагтай байх.</p> <p>15. Кабель, шилэн кабелийн шөрмөснүүдийг хаягжуулж дугаарласан схемчилсэн зургийг ажил гүйцэтгэсэн актад хавсаргасан байх.</p> <p>16. Бичигч төхөөрөмжийн хатуу диск нь SEAGATE SATA төрлийн 10 ТВ багтаамжтай эсхүл түүнтэй дүйцэх хатуу дисктэй 30 өдрөөс доошгүй хугацааны бичлэг хадгалахаар тооцоолж суурилуулсан байх.</p> <p>17. Хяналтын дэлгэц нь 55 инч-ээс дээш нэг дэлгэцэнд 36 камерын дүрс H.265+ форматаар 24/7 горимоор харуулаар дэлгэцийг тооцоолж суурилуулна.</p> <p>18. Камерын сүлжээний бүтэц зохион байгуулалтыг компанийн дотоод сүлжээний төлөвлөлттэй уялдуулан зохион байгуулж холбоо дохиоллын инженерийн заавраар IP хаяг, нэршил, хаягжилтыг өгсөн байх.</p> <p>19. Бичигч төхөөрөмж нь алсаас хандаж тохиргоо хийх боломжтой USB, VGA, HDMI HDMD оролттой бичлэгийг флаш, сервер сд двд дискэнд архивлах хадгалах хуулбарлах боломжтой байх.</p> <p>20. Хайрцгийн гадна талд таних тэмдэг, дугаарлалт, санамж анхааруулга дотор талд нь техник хэрэгслүүдийн холболтын схем, зураглал, зааварчилгаа зэргийг ил харагдах байдлаар хийж өгсөн байх.</p> <p>21. Сүлжээний зангилаа цэгт байрлах сүлжээний төхөөрөмжүүдийг цахилгааны хэлбэлзэл, тасалдлаас хамгаалах цахилгааны болон сүлжээний төхөөрөмжүүд хэвийн ажиллах цахилгааны найдвартай эх үүсвэр оруулж цахилгааны тэжээлийг тусад нь татаж 30 доошгүй минут барих тог баригчийг холболтын хайрцаг тус бүрт суурилуулж хамгаалсан байна.</p> <p>22. Ажлыг гүйцэтгэх явцад ажлын талбарт ажиллаж буй ажилчдад хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгааг тогтмол өгч, аюулгүй ажиллагааны нөхцөлийг бүрэн хангаж ХАБ ажилуулах.</p> <p>23. Сүлжээний төхөөрөмжүүд байрлах зангилаа цэгийн хайрцаг /rack-/ыг сүлжээний төхөөрөмжүүдийг өргөтгөх, нэмэхэд саадгүй</p>
--	--

	<p>байдлаар нөөц зйтай, цахилгааны нэмэлт холболт хийх боломжтой байхаар тооцоолон суурилуулсан байх бөгөөд сүлжээний кабелиудыг patch panel ашиглан холбож, хаягжуулсан байна.</p> <p>24. Барилга байгууламжийн дээвэр цамхаг дээр хяналтын камер суурилуулсан тохиолдолд хананаас 1,2 метр, шонгуй газар бетон 8 метр өндөртэй шон суурилуулж 3-4 метр өндөрт камер сууриссан байх.</p> <p>25. Шинээр суурилуулах камерын байршлыг захиалагчаас өгсөн зургийн дагуу суурилуулж зөвшилцэж ажиллах.</p> <p>26. Тухайн цехийн дотор орчныг хянах зориулалттай камерын хяналтын цэг нь харьяа үйлдвэрийн камерын хяналтын төв дээр байхаас гадна цехийн операторын өрөөнд хэсэгчилсэн байдлаар давхар хянах боломжтой бичигч дэлгэц хөргөлтийн сэнстэй рак суурилуулсан байна.</p> <p>27. Гар утас, таблет, компьютер зэрэг бүх төрлийн android, iphone, harmony үйлдлийн систем төхөөрөмжүүдээс хандах хэсэгчлэн болон бүрэн хянах боломжтой байх.</p> <p>28. Нийлүүлсэн бараа материалын засвар үйлчилгээг 1 жилийн хугацаатай хийж гүйцэтгэх</p>
Үйлдвэр барилга, байгууламжийг камержуулах хяналтын камерын ерөнхий шаардлага	<ol style="list-style-type: none"> Дэлхийн томоохон үйлдвэрлэгч Hikvision эсхүл түүнтэй дүйцэх хяналтын камер байх. Хяналтын камер нь IP хаягжилт авдаг, 4 Мега пиксел ба түүнээс дээш нягтралтай, PoE дээмждэг дижитал хэлбэрийн олон улсын стандартад нийцсэн, дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн Hikvision брэндийн эсхүл түүнтэй дүйцэх үйлдвэрийн орчны нэгдсэн стандарт болох ONVIF болон Hikvision HD-SMPTE эсхүл түүнтэй дүйцэх 296M (720P), SMPTE 274M (1080P) стандартуудыг дээмждэг өнгөт шөнийн хараатай дулаан утаа дөл гал царай таних мэдрэгчтэй камерууд байх. Үйлдвэрийн дотор гадна болон талбай, пост, тоноглолтуудыг энгийн өнгөт шөнийн хараатай, дулаан, дөл, утаа царай таних мэдрэгчтэй, загасан нүд, панаром, PTZ 180, 360 эргэдэг камеруудаас үйлдвэрийн орчин нөхцөлд тохирсон хяналтын камерыг суурилуулж нь ус чийгээс хамгаалагдсан, битүүмж сайтай шөнийн хараатай IR IP66 IP67 стандартын шаардлага хангасан Hikvision эсхүл түүнтэй дүйцэх байх. Камерын системийн гадна ажиллах тоноглол нь Монгол орны цаг уур, орчинд тохирсон, -30C -ээс +70C температурт ажилладаг, ус, чийгшил, тоосжилтын хамгаалалт битүүмжлэл сайтай байх. Камерын сүлжээний бүтэц зохион байгуулалтыг компанийн дотоод сүлжээний төлөвлөлттэй уялдуулан зохион байгуулж холбоо дохиоллын инженерийн заавраар IP хаяг нэршлийг өгч одоо ашиглаж байгаа бичлэг нь хийгдэхгүй байгаа камеруудыг засварлан гаргаж боломжит бүхий л хяналтын камеруудыг нэгтгэн гаргасан байх. Hikcentral эсхүл түүнтэй дүйцэх программ хангамж дээр камерын аюулгүй байдал бүх төрлийн функцуудын тохиргоо үйлчилгээг хийлгэж системийг цогцоор нь ажиллуулсан байх. Тавантолгой түлш ХХК-аас томилогдсон ажилтнуудыг Hikcentral эсхүл түүнтэй дүйцэх программ хангамж дээр бүрэн ажиллуулж сургах. Хяналтын цэгийн байрлал тухайн орчны гэрэлтүүлэг, онцлог байдлаас хамаарч маш бага гэрлийн орчинд дүрсний чанар өндөртэй, хөдөлгөөнтэй эргэдэг татдаг камертай бусад төрлийн камеруудыг хосолсон байдлаар суурилуулсан байх.
Үйлдвэр барилга, байгууламжийг камержуулах хяналтын камерын нарийчилсан шаардлага	<ol style="list-style-type: none"> Үйлдвэрийн дотор, гадна орчинд суурилуулах хяналтын камер нь: Hikvision ColorVu Bullet Camera DS-2CD2T47G2-L H.265+ 4MP 4mm эсхүл түүнтэй дүйцэх доошгүй үзүүлэлттэй IP хаягжилт авдаг, 4Mega пиксел ба түүнээс дээш нягтралтай, PoE дээмждэг дижитал хэлбэрийн H.265+ Onvif болон HD-SMPTE 296M (720P), SMPTE

	<p>274М (1080P) стандартыг хангасан линз нь 1.8–4 мм хүртэл фокустай, 30м-ээс доошгүй зайд ажиллах ус чийгээс хамгаалагдсан, битүүмж сайтай шөнийн хараатай IR IP66 IP67 стандартын шаардлага хангасан H.265+ форматаар бичдэг Харанхуйд хөдөлгөөний зууралтгүй, өнгөтөөр харах, камерын урдаас туссан шууд гэрлийн нөлөөний эсрэг функцтэй байх - Wide Dynamic Range Ус чийг, тоос, шороо, доргилтоос хамгаалагдсан IP67 стандартын шаардлагуудыг хангасан байх IPv4/v6, HTTP, HTTPS, QoS болон бусад сүлжээний протоколуудыг дэмжиж ажилладаг байх. Сүлжээгээр цахилгааны тэжээл (PoE -IEEE 802.3at) авдаг байх. Hik-Connect, Hik-Central программ хангамжтай холбогддог байх Darkfighter технологиор ажилладаг байх Гадаа зориулалттай байх 24/7 өнгөлөг дүрслэл 1/1.8" Progressive Scan CMOS Min. Illumination:Color: 0.0005 Lux @ (F1.0, AGC ON), 0 Lux with white light 1/3 s to 1/100,000 s θнцөг: Pan: 0° to 45°, tilt: 0° to 90°, rotate: 0° to 180° камер байх.</p> <p>2. Хөдөлгөөнт загасан нүд, панаром, PTZ 180, 360 эргэдэг татдаг камер нь: Hikvision ColorVu 12MP 25x optical+64x digital zoom PTZ Camera DS-2DE7A812MCG-EB үйлдвэрийн орчны шөнийн хараатай, хана шонгоос 120м зайд суурилуулсан, гадна зориулалтын Hikvision эсхүл түүнтэй дүйцэх доошгүй үзүүлэлттэй байх. Хамгийн багадаа 4ш бие даасан H.265+ урсгалтай байх бөгөөд дараах зориулалтаар тус бүрийн хэрэглээний онцлогт нь тааруулж тохируулах боломжтой байх. (Оператор, Бичлэгийн сервер, SDXC Нөөц бичлэг, Зайн хандалт болон бусад хэрэглээ. Урдаас туссан шууд гэрлийн нөлөөний эсрэг функцтэй байх - /Wide Dynamic Range picture, Wide Dynamic Range contrast/ Бага гэрлийн орчинд хөдөлгөөнийг мэдэрч ямар ч сарнил, гацалт, хөдөлгөөний зууралт үүсэхгүй байх. Хөдөлгөөнт камер удирдах төхөөрөмж /Joystick/-өөр удирдах боломжтой байна. Image Sensor:1/3" Progressive Scan CMOS Min. Illumination:Color: 0.003 Lux @ (F1.4, AGC ON), B/W: 0 Lux with IR Day & Night: IR cut filter Shutter Speed:1/3 s to 1/100,000 s Angle Adjustment:Pan: 0° to 360°, tilt: 0° to 75°, rotate: 0° to 360° Wide Dynamic Range:120 dB 2.8 mm, horizontal FOV 103°, vertical FOV 55°, diagonal FOV 123° 4 mm, horizontal FOV 83°, vertical FOV 45°, diagonal FOV 98° 6 mm, horizontal FOV 53°, vertical FOV 28°, diagonal FOV 62° байх.</p> <p>3. Дулаан, дөл, утая царай таних мэдрэгчтэй камер нь: Hikvision HM-TD2638-10/G0/T1Y Thermal HeatPro Cameras Dual lens 10mm эсхүл түүнтэй дүйцэх байх. Дүрсний хэмжээс, нягтрал: 1280x720, HD 720p, 4MP ба түүнээс дээш байх Хамгийн багадаа 4ш бие даасан H.265+ урсгалтай байх бөгөөд дараах зориулалтаар тус бүрийн хэрэглээний онцлогт нь тааруулж тохируулах боломжтой суурилуулсан байх. (Оператор, Бичлэгийн сервер, SDXC Нөөц бичлэг, Зайн хандалт болон бусад хэрэглээ.) Image Sensor:VOx Uncooled Focal Plane Arrays Нягтрал:160 × 120 Пикселийн интервал: 17 μm Долгионы зурvas :8 μm to 14 μm Хамгийн багадаа :0.2 m White Balance:Auto/Manual/ATW (Auto-tracking White Balance)/Indoor/Outdoor/Daylight Lamp/Sodium Lamp Day & Night Mode:IR cut filter with auto switch WDR:120 dB IR Distance:Up to 15 m Temperature Range: -40 °C to 60 °C мэдэрдэг байх.</p> <p>4. Бичлэгийн төхөөрөмж нь: SAN Storage серверийн төрлийн шийдэл байж болно. Бусад шийдлийг захиалагчид танилцуулж болно. Бүх камерын хувьд 60 хоногоос дээш хоногийн бичлэг хадгалах боломжтой, камерын бичлэгийг хялбар, хурдан хугацаанд ухраах, зогсоох боломжтой төхөөрөмжтэй байна.</p> <p>5. Бичлэгийн программ хангамж нь : Албан ёсны лицензтэй хугацаагүй Hikcentral программ хангамж байх. Хяналтын камерын тоог өргөтгөх боломжтой, үнэгүй сайжруулалт хийх боломжтой байх. Системийн ачаалал болон гэмтлийг байнгын хянах функцтэй байх. Зарлан мэдээлэх болон гамшигийн аюулыг нийтэд мэдээлэх системтэй холбогдон ажиллах боломжтой байх. Хөдөлгөөнт хэрэглэгч нь төв системээс мэдээлэл тайлан авах, системд алсын оператор</p>
--	--


	горимоор оролцох, хяналтын камеруудыг удирдах, мөн шаардлага гарсан үед тухайн төхөөрөмжийн бичлэгийг шүүж үзэх боломжтой байх.
ЗАХИАЛАГЧИЙН ХЯНАЛТЫН АЖИЛ	<ol style="list-style-type: none"> Камер суурилуулах, нэгтгэх, диспетчериин хяналтын төв байгуулах ажлын явцад гарах зураг, төсөвтэй холбоотой асуудлыг газар дээр нь холбогдох мэргэжилтнүүдтэй хамтран шийдвэрлүүлж байна. Гүйцэтгэгч байгууллага нь заагдсан ажлын тоо хэмжээ, зургийн дагуу чанарын өндөр түвшинд стандартын дагуу гэрээний хугацаанд багтаан гүйцэтгэх нөхцөлийг бурдуулэн ажиллана. Ажлын талбайд ажлын журналыг байнга бэлэн байлгаж, холбогдох хяналтын инженерүүдийн өгсөн шаардлага, дүгнэлтийг журналд бичиж хөтлөн, цаг тухайд нь захиалагчаар баталгаажуулж байна. Ажил гүйцэтгэх явцад байнга фото зургаар баталгаажуулан, далд ажлын акт үйлдэж, захиалагчийн хяналтын инженерүүдээр баталгаажуулна. Ажлыг гүйцэтгэх технологийн үе шатыг захиалагч талтай нарийн тохиролцож, гүйцэтгэх явцад технологийн үе шат бурд гүйцэтгэсэн ажлыг захиалагчийн хяналтын инженерт үзүүлж байх ба техникийн шаардлага хангасан гэж үзвэл ил, далд ажлын актыг үндэслэн дараагийн үе шатны ажлыг гүйцэтгүүлэх байдлаар захиалагч талаас бүх технологийн үйл ажиллагаанд хяналт тавина.
8.Хөдөлмөрийн аюулгүй байдал	<ol style="list-style-type: none"> Үйлдвэрийн орчин нөхцөлд шат тавцан угсрал, камер суурилалтын ажил гүйцэтгэхдээ хөдөлмөр хамгаалал, техникийн аюулгүй ажиллагаа, цахилгаан кабель, камер суурилуулах стандартыг чанд мөрдөж ажиллана. Орчны эрүүл ахуйн байдалд тавигдах стандартын шаардлага, байгаль, экологийн тэнцвэрийг хадгалах, хаягдалгүй технологи ашиглах болон норм, дүрмийг баримтална. Угсралт, монтажны ажлыг холбогдох стандарт, шаардлагын дагуу чанарын өндөр түвшинд гүйцэтгэсэн байх.
9. Ажиллах горим	24/7 цагаар ажиллаж бичлэгээ 60-аас доошгүй хоног хадгалдаг байх.
10.Захиалагч байгууллага	“Тавантолгой түлш” ХХК
11. Онцгой нөхцөл	<ol style="list-style-type: none"> Холбоо дохиоллын ажлыг “Тавантолгой түлш” ХХК-ийн ерөнхий төлөвлөгөө зургийн дагуу үйлдвэрийн дарга, ерөнхий инженер, захиалагчийн хяналт, мэдээлэл технологийн хэлтсийн инженерүүдтэй зөвшилцэж үйлдвэрийн орчин нэгдсэн системтэй уялдуулж зураг материалын түүвэр гаргаж ажлыг гүйцэтгэнэ. Системд ашиглаж байгаа тоног төхөөрөмж нь 24/7 горимд тасралтгүй ажиллах нөхцөлөөр хангагдсан байх ба дурс хоцрох, тасалдах, хөдөлгөөнт камеруудыг удирдах үед гацахгүй байх Төлөхяналтын системд ашиглаж байгаа техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн баталгаат хугацаа 1 жилээс багагүй байх, засвар үйлчилгээний баталгаат хугацаа 1 жил байх. Программ хангамжийн лицензийн хугацаа Lifetime байна. Лицензийн хугацаанд үйлдвэрлэгчээс шууд дэмжлэг авах /support/ боломжтой байх Аливаа эрсдэлийг урьдчилан тооцоолсон байх. Тухайн ажлыг гүйцэтгэхдээ захиалагчийн хяналт, мэдээлэл технологийн холбоо, дохиоллын инженерүүдтэй хамтран ажиллах. Монгол Улсын “ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ” ХУУЛИЙН 12 дүгээр зүйл. Техникийн тодорхойлолт.12.5.Техникийн тодорхойлолтыг нарийвчлан тодорхойлох боломжгүй бол энэ тухай үндэслэл бүхий тайлбарыг дурдсаны үндсэн дээр зөвхөн тухайн бараанд холбогдуулан энэ хуулийн 12.4-т заасан шаардлага, нөхцөлийг тавьж болох бөгөөд энэ тохиолдолд “эсхүл түүнтэй дүйцэх” гэсэн тодотгол хэрэглэх гэж заасны дагуу “эсхүл түүнтэй дүйцэх” гэсэн тодотгол хэрэглэсэн болно.


ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

**ҮЙЛДВЭРИЙН
ОРЧНЫ ХЯНАЛТЫН КАМЕРЖУУЛАЛТЫН НЭГДСЭН
СИСТЕМ БИЙ БОЛГОХ НӨӨЦӨНД АВАХ БАРАА МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ**

№	Материалын нэр	Загвар	Техникийн тодорхойлолт	Тоо /ширхэг/
1	Дотор камер /Дуу бичигч микрофонтой /	HIKVISION эсхүл түүнтэй дүйцэх	HIKVISION DS-2CD2443G0-iW H.265+ PIR хөдөлгөөн илрүүлдэг байх эсхүл түүнтэй дүйцэх	50
2	Хяналтын гадна камер /Шөнийн хараатай өнгөт/	HIKVISION эсхүл түүнтэй дүйцэх	Hikvision ColorVu Bullet Camera H.265+ 4MP 4mm DS-2CD2T47G2-L эсхүл түүнтэй дүйцэх	50
3	Хяналтын дулаан мэдрэгчтэй камер	HIKVISION эсхүл түүнтэй дүйцэх	Hikvision HM-TD2638-10/G0/T1Y Thermal HeatPro Cameras Dual lens 10mm эсхүл түүнтэй дүйцэх	20
3	Хар хайрцагтай хяналтын камер	iROAD эсхүл түүнтэй дүйцэх	iROAD брэндийн FX2 black box эсхүл түүнтэй дүйцэх	4
4	Энгэрийн хяналтын камер	Axis эсхүл түүнтэй дүйцэх	Axis W101 camera эсхүл түүнтэй дүйцэх	20
5	Дотор камер /Утасгүй сүлжээгээр холбогддог иж бүрдэл /	HIKVISION эсхүл түүнтэй дүйцэх	Hikvision NK44W0H-1T(WD)(D) 4MP WiFi KIT 4 Bullet Cameras + NVR + 1TB HDD эсхүл түүнтэй дүйцэх	2
6	Сүлжээний дотор кабель	HIKVISION эсхүл түүнтэй дүйцэх	Hikvision Indoor Network cable UTP CAT6 0.55mm 23AWG Network cable DS-1LN6U-SC0 эсхүл түүнтэй дүйцэх	20
7	Сүлжээний гадна кабель	HIKVISION эсхүл түүнтэй дүйцэх	Hikvision Outdoor Network cable STP CAT6 эсхүл түүнтэй дүйцэх	20

“ТАВАНТОЛГОЙ ТУЛШ” ХХК -ИЙН ҮЙЛДВЭРИЙН ОРЧНЫ ХЯНАЛТЫН КАМЕРЖУУЛАЛТЫН НЭГДСЭН СИСТЕМ БИЙ БОЛГОХ СУУРИЛУУЛАХ КАМЕРЫН ЗУРАГ





**ЗҮҮН ҮЙЛДВЭРИЙН 2-Р ЦЕХИЙН ГАДНА, ДОТНО
КАМЕРЖУУДАЛТЫН БАЙРШЛЫН ПЛАН ЗУРАГ**

БАТЛАВ
“ТАВАНТОГОЙ ТУШИ” ХХК - МИНДАН
ЧУЛДВЭРГИЙН ДАРГА
ДЕБҮҮНИЙ
ҮНН




СХ.
Зүүн үйлдвэрийн 2-р цехийн гадна, дотно
камержуудалтын байршилын план зураг
Хийсэн: М.Минь-Болоев
Хийсэн: Н.Баярхолцын
Гийнзүйжан А.Солиев
Гийнзүйжан К.Кодойдерзен
“ТАВАНТОГОЙ ТУШИ”ХХК



Мэдээлэл:	Чигилт:	Материал:	Олондо:
		Масамай:	Эрэлжийн флагийн Худалс:

8
A3

**ЗҮНН УЙДВЭРЭЙН З-Р ЦЕХИЙН ГАДНА, ДОТНО
КАМЕРКУУЛПЛЫН БАЙРШЫН ПЛАН ЗУРАГ**



Бараа нийлүүлэлтийн хуваарь

№	Барааны нэр	Тоо хэмжээ	Хэмжих нэгж, тун	Өгөгдлийн хүснэгтэд заасан барааг хүргэх эцсийн цэг	Бараа нийлүүлэх хугацаа	
					Захиалагч бараа хүлээн авах хугацаа (эхлэх болон дуусах хугацаа)	Нийлүүлэгчийн санал болгох хугацаа (Оролцогч энэ баганыг бөглөнө)
1	2	3	4	5	6	7
1	Орчны хяналтын камерын нэгдсэн систем нийлүүлэн угсралт сууринуулалт хийх	186	ширхэг	Зүүн үйлдвэрийн орчны хяналтын камерын нэгдсэн систем	Гэрээ байгуулсан өдрөөс хойш 60 хоногийн дотор нийлүүлэн угсралт хийх	

V БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ЖИШИГ МАЯГТУУД

Маягт 1. Тэндер илгээх маягт

Маягт 2. Барааны үнийн задаргаа

Маягт 3. Ижил төстэй бараа нийлүүлсэн гэрээний мэдээлэл

Маягт 4. Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл

Маягт 5. Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл

Маягт 6. Нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалт

“Тавантолгой түүлш” ХХК-д

Манай [оролцогчийн нэр] нь танай байгууллагаас зарласан [тендер шалгаруулалтын нэр, дугаар] тендер шалгаруулалтад [үнийн хөнгөлөлт тооцоогүй тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендер шалгаруулалтын баримт бичигт заасан хуваарийн дагуу бараа нийлүүлэхээр, дор дурдсан нөхцөлийг баталж энэхүү тендер (цаашид “тендер” гэх)-ийг хүргүүлж байна. Үүнд:

1. Тендер шалгаруулалтын баримт бичиг, түүнд заасан гэрээний нөхцөл (гэрээний ерөнхий нөхцөл, тусгай нөхцөл, гэрээ баталгаажуулах маягт)-тэй танилцаж, бүрэн хүлээн зөвшөөрч тендер шалгаруулалтад оролцсон.
 2. Оролцогч, түүний түншлэлийн гишүүн худалдан авах ажиллагаанд оролцохтой холбоотой хуулиар хориглосон нөхцөлд хамаарахгүй бөгөөд үүний дотор дараах нөхцөлийг гэрчилж байна. Үүнд:
 - 2.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7.1-д заасан нөхцөл үүсээгүй;
 - 2.2. Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, түүний эцсийн өмчлөгч, хөрөнгө эзэмшигч, хамтрагч, эсхүл эдгээрийг гүйцэтгэж байгаа хувиараа аж ахуй эрхлэгч нь Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20.2 дахь хэсэгт заасан албан тушаал эрхэлж байсан болон эрхэлж байгаа хүн, эсхүл түүнтэй хамаарал бүхий этгээд биш;
 - 2.3. Захиалагчийн удирдлага, хяналт, захиргаанд ажилладаг албан тушаалтанд ашиг олгодоггүй;
 - 2.4. Оролцогчийг төлөөлж буй этгээд нь Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 21.1.3 дахь заалтад заасан хязгаарлалтад хамаарахгүй.
 3. Тендертэй холбоотой нотлох баримт, мэдээллийг холбогдох этгээдээс гаргуулах эрхийг захиалагчид үүгээр олгож байна.
 4. Тендерт үнийн хөнгөлөлт [“санал болгоно” эсхүл “санал болгохгүй” гэж бичих]. [Хэрэв үнийн хөнгөлөлт санал болгох бол түүнийг хэрхэн хэрэглэх нөхцөл, аргачлалыг бичих].
 5. Тендер нь тендер шалгаруулалтын баримт бичигт заасны дагуу тендер нээснээс хойш **ажлын 30** хоногийн хугацаанд хүчинтэй байна.
 6. Хуулийн 7.1, 22.2, 56.5-д заасныг зөрчсөн болон тендер шалгаруулалтад үнэн зөв, зөрүүгүй орчуулга ирүүлэх үүргээ зөрчсөн тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэх үндэслэл болохыг хүлээн зөвшөөрч байна.
 7. Тендерт санал болгосон бараа нь оюуны өмчийн зөрчилгүй, эрхийн болон биет байдлын догондолгүй болохыг баталж байна.
 8. Тендерийг холбогдох журмын дагуу бусад оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч, тендерийг нууцлах аливаа үүргээс захиалагчийг бүрэн чөлөөлж байна. **[Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд,**
эсхүл түүнээс эрх олгогдсон этгээдийн нэр,
албан тушаал, гарын үсэг,
байгууллагын тамга, тэмдэг]:
- Хаяг:**

Маягт 2 Барааны үнийн задаргаа

[Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд,

эсхүл түүнээс эрх олгогдсон этгээдийн нэр,

1	2	3	4	5	6	7	8	9	10	11
№	Барааны нэр	Гарал үүслийн улс ¹	Тоо хэмжээ	Хэмжих нэгж, тун	Нэгж үнэ	Нэр төрөл бүрийн бүгд үнэ (4x6)	Барааг эцсийн цэгт хүргэхэд шаардагдах дотоодын тээвэрлэлт болон бусад үйлчилгээний үнэ	Бараа нийлүүлэхэд ногдох татвар, хураамж	Нэр төрөл бүрийн нийт үнэ (7+8+9)	Монгол Улсын гарал үүсэлтэй бараа мөн эсэх ²
1										Tийм/Үгүй
2										
...										
								Тендерийн нийт үнэ		

албан тушаал, гарын үсэг, байгууллагын

тамга, тэмдэг]:

¹ ТШЗ-ны 18.6.2-ын дагуу ирүүлсэн баримт бичигт дурдсан барааны гарал үүслийн талаарх мэдээлэлтэй ижил байна.

² Монгол Улсын гарал үүсэлтэй бараа мөн эсэх гэдэгт “тийм” гэж бөглөсөн бол түүнийг нотлох баримт бичгийг хавсаргана.

Маягт 3

Ижил төстэй бараа нийлүүлсэн гэрээний мэдээлэл

Гэрээний нэр	Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас	Төсөвт өртөг	Хугацаа /эхэлсэн, дууссан/

Маягт 4

Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл

Гэрээний нэр	Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас	Төсөвт өртөг	Гэрээ эхэлсэн хугацаа	Хүлээгдэж буй гүйцэтгэлийн хувь, мөнгөн дүнгээр	Дуусах хугацаа

Оролцогчийн нэр: [түншлэлийн гишүүн тус бүр бүрэн дуусгавар болсон гэрээ тус бүрээр бөглөнө].

1.	Захиалагчийн нэр
2.	Гэрээний нэр
3.	Гэрээний дугаар
4.	Гэрээ байгуулсан огноо
5.	Гэрээ дуусгавар болсон огноо
6.	Гэрээний дүн
7.	Гэрээ гүйцэтгэсэн хаяг, байршил
	Гэрээнд оролцсон байдал (нэгийг сонгох) <input type="checkbox"/> Үндсэн нийлүүлэгч <input type="checkbox"/> Түншлэлийн гишүүн <input type="checkbox"/> Туслан гүйцэтгэгч

Маягт 6

Нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалт

	Нууцалсан баримт бичиг, мэдээлэл	Хүний эмзэг мэдээлэлд хамаарах хууль зүйн үндэслэл
1.		
2.		
3.		
4.		
5.		

VI БҮЛЭГ. ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ

Санамж

Захиалагч, түүнээс томилсон үнэлгээний хороо нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “хууль” гэх)-ийн дагуу тендер шалгаруулалт зохион байгуулж бараа худалдан авахад энэхүү гэрээний нөхцөлийг боловсруулж ашиглана.

Гэрээний ерөнхий нөхцөл (цаашид “ГЕН” гэх) болон гэрээний тусгай нөхцөл (цаашид “ГТН” гэх), түүнд заасан бусад баримт бичиг нь хоёр талын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлох баримт бичиг болно. Энэ гэрээ нь захиалагчаас бараа, түүнтэй холбогдох үйлчилгээг худалдан авах харилцааг зохицуулсан жишиг заалтуудыг агуулна. Гэрээний нөхцөлийг боловсруулахад ГЕН-д өөрчлөлт оруулахгүй.

ГТН-ийг тухайн бараа худалдан авах нөхцөлд тохируулан ГЕН-ийн холбогдох зүйл, заалтыг тодруулах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах зорилгоор ашиглана. Гэрээний нөхцөлийг бэлтгэхэд дараахыг анхаарна:

1. ГЕН-ийн аль нэг зүйлд тодорхой мэдээллийг ГТН-д тусгахаар заасан бол холбогдох мэдээллийг ГТН-д заавал оруулна. ГЕН-ийн аль нэг зүйл, заалтыг тухайн бараа худалдан авахад хэрэглэхгүй бол энэ тухай ГТН-д тусгах;
2. Гэрээ баталгаажуулах маягтад шалгарсан оролцогчийн мэдээлэл болон “хамгийн сайн” үнэлэгдсэн тендерийн мэдээллийг тусгах;
3. Гэрээний үнийг тендерийн үнэд залруулга болон хөнгөлөлтийг тооцож, нэг валютад хөрвүүлсний дараах үнээр тогтоох;
4. Нийлүүлэх бараа, дагалдах үйлчилгээний дэлгэрэнгүй тодорхойлолт, зураг зэргийг гэрээнд хавсаргах;
5. ГЕН, ГТН болон холбогдох хавсралтууд нь өөр хоорондоо зөрчилдөөнгүй байх;
6. Гэрээ баталгаажуулах маягтын хаалтан дотор бичсэн жишээ, зааврыг тендер шалгаруулалтын үр дүнд шалгарсан тендерийн нөхцөлд тохирох үг өгүүлбэр, тоо хэмжээ зэргээр тусгана. ГТН-д заасан зарим жишээ, нөхцөлийг зөвхөн санаа өгөх зорилгоор оруулсан ба тухайн гэрээний онцлогийг харгалзан захиалагч эцэслэнэ.
7. Нийтийн албан дийлийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан гэрээ байгуулах албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдсон хориглолт, хязгаарлалттай танилцаж, судалсан байх шаардлагатай болохыг анхаарна уу.

ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

НЭГ.ТОДОРХОЙЛОЛТ БА ТАЙЛБАР

Тодорхойлолт

- 1.1. Гэрээнд хэрэглэсэн үг, хэллэг, илэрхийлэл нь дор дурдсан утгыг агуулна:
 - 1.1.1. “Бараа” гэж Нийлүүлэгчээс Захиалагчид нийлүүлэхээр Тендерт ирүүлсэн хөрөнгийг;
 - 1.1.2. “Дагалдах үйлчилгээ” гэж бараа нийлүүлэхтэй холбоотой угсралт, суурилуулалт, сургалт, засвар үйлчилгээ болон Нийлүүлэгчийн үзүүлэх бусад үйлчилгээг;
 - 1.1.3. “Захиалагч” гэж Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;
 - 1.1.4. “Нийлүүлэгч” гэж гэрээ байгуулах эрх авсан бөгөөд Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;
 - 1.1.5. “Талууд” гэж Захиалагч болон Нийлүүлэгчийг хамтад нэрлэснийг;
 - 1.1.6. “Хууль” гэж Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг;
 - 1.1.7. “Бараа нийлүүлэх нөхцөл” гэж Захиалагчийн техникийн тодорхойлолтод нийцүүлж Тендерт тусгасан бараа бэлтгэх, нийлүүлэх, дагалдах үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг ойлгоно. Тендерт тусгайлан заагаагүй бараа нийлүүлэх нөхцөлийг Техникийн тодорхойлолтод тусгаснаар ойлгоно. Хуулийн 30.2, 34.2-т заснаар хэлэлцээ хийсэн тохиролцоо нь Гэрээнд тусгагдсан бол Бараа нийлүүлэх нөхцөлийн нэг хэсэг болно.
 - 1.1.8. “Бараа нийлүүлэх газар” гэж барааг хүлээлгэн өгөх болон дагалдах үйлчилгээ үзүүлэх газрыг;
 - 1.1.9. “Доголдол” гэж нийлүүлсэн бараа, дагалдах үйлчилгээний барааны шинж байдал, чанар тоо хэмжээ нь Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерээс зөрүүтэй байхыг;
 - 1.1.10. “Баталгаат хугацаа” гэж нийлүүлсэн барааг зориулалтын дагуу өрдийн байдлаар ашиглах явцад бараанд илэрсэн доголдлыг нийлүүлэгч хариуцах хугацааг;
 - 1.1.11. “Гомдлын шаардлага гаргах хугацаа” гэж гэрээгээр баталгаат хугацаа тогтоогоогүй бол Захиалагчаас доголдолтой холбогдуулж Нийлүүлэгчид шаардлага гаргах хугацааг;
 - 1.1.12. “Захиалагчийн төлөөлөгч” гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлах, гэрээнээс татгалзахаас бусад Гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар Нийлүүлэгчтэй

харилцах, хяналтыг хэрэгжүүлэх эрхтэй Захиалагчаас томилогдсон этгээдийг;

1.1.13. “Нийлүүлэгчийн төлөөлөгч” гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлах, гэрээнээс татгалзахаас бусад Гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар Захиалагчтай харилцах эрхтэй Нийлүүлэгчээс томилогдсон этгээдийг;

1.1.14. “Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал” гэж талуудын хараа хяналтаас гадуур болсон, урьдчилан таамаглах боломжгүй, гэрээний үүргийг гүйцэтгэх боломжгүй болгох байгалийн гамшиг, Төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтны үйлдэл /эс үйлдэхүй/, гоц халдварт, олон улсын хөл хориот өвчин, цар тахлын улмаас бүх нийтийн хорио тогтоосон нөхцөл байдал бий болохыг ойлгоно.

Гэрээний тайлбар

1.2. Гэрээг тайлбарлах, хэрэглэхэд дараах журмыг баримтална:

1.2.1. Ганц тоог илэрхийлсэн үг нь олон тоог, олон тоогоор илэрхийлсэн үг нь ганц тоог хамааруулж болно.

1.2.2. Бүлэг болон зүйлийн гарчиг нь гэрээг системчлэх зорилготой бөгөөд гэрээг тайлбарлахад ашиглахгүй.

1.2.3. Зүйл, заалт, үг, өгүүлбэрийг энэ гэрээнд заасан нэр томьёог үндэслэн тайлбарлах бөгөөд гэрээнд тайлбарлаагүй тохиолдолд гэрээний агуулгад нийцүүлэн тайлбарлана. Хэрэв гэрээний агуулгад үндэслэн тайлбарлах боломжгүй тохиолдолд Иргэний хуульд заасан журмыг баримтлан тайлбарлана.

1.2.4. Ерөнхий нөхцөл болон тусгай нөхцөл хоорондоо зөрчилдсөн тохиолдолд тусгай нөхцөлийг баримтална.

1.2.5. Гэрээний хэрэгжилтийн явцад харилцах хэл нь Монгол хэл байх бөгөөд гэрээг өөр хэл дээр байгуулснаас хувиуд нь хоорондоо зөрчилдсөн тохиолдолд Монгол хэл дээрх хувийг баримтална.

ХОЁР. НИЙЛҮҮЛЭГЧ

Бараа нийлүүлэх

2.1 Нийлүүлэгч нь гэрээнд заасан бараа нийлүүлэх нөхцөл, нийлүүлэлтийн хуваарь, ГТН-д заасан хугацааг баримтлан Бараа нийлүүлэх, Дагалдах үйлчилгээ үзүүлэх үүрэгтэй.

2.2 Нийлүүлэгч гэрээний дагуу Дагалдах үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай ажилтан, тоног төхөөрөмж зэргийг Тендерт санал болгосноор оролцуулах ба гүйцэтгэлийн явцад эдгээрт өөрчлөлт орох зайлшгүй

	шаардлагатай нөхцөл үүссэн бол Захиалагчаас урьдчилан бичгээр зөвшөөрөл авна.
	2.3 ГЕН-ийн 2.2-т заасны дагуу өөрчлөлт оруулсан тохиолдолд Захиалагчийн шаардсан техникийн чадавх, туршлагын шаардлагыг хангасан байна.
	2.4 Нийлүүлэгч нь Барааг нийлүүлэхэд зайлшгүй шаардлагатай баримт бичиг, бусад зүйлийг гаргуулахыг үүссэн тохиолдолд Захиалагч ердийн боломжит хугацаанд гаргаж өгнө.
Бараа нийлүүлэх газар	2.5 Бараа нийлүүлэх болон Дагалдах үйлчилгээ үзүүлэх газрыг ГТН-д заана.
Бараа нийлүүлэх хугацаа, түүнийг сунгах	2.6 Бараа нийлүүлэх хугацааг нийлүүлэлтийн хуваарийг үндэслэн ГТН-д заана.
	2.7 Нийлүүлэгч дараах нөхцөл бий болсон тохиолдолд бараа нийлүүлэлтийн хугацааг сунгах тухай хүсэлт гаргаж болно:
	2.7.1 Захиалагч ГЕН-ийн 2.4-д заасан үүргээ зохих ёсоор гүйцэтгэгүй;
	2.7.2 Барааг гэрээнд заасан хугацаанд нийлүүлэх боломжгүйд хүргэсэн Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон.
	2.8 Захиалагч ГЕН-ийн 2.7-д заасан нөхцөлийн аль нэг нь бүрдсэн гэж үзвэл Нийлүүлэгчийн хүсэлтийг үндэслэн хугацааг сунгаж болно.
	2.9 ГЕН-ийн 2.7.2-т заасан нөхцөл байдал үүссэн болохыг Нийлүүлэгч нотлох үүрэгтэй.
Барааг хүлээлгэн өгөх	2.10 Нийлүүлэгч нь Барааг ГТН-д заасан нөхцөлөөр хүлээлгэн өгч, дагалдах үйлчилгээг бүрэн үзүүлж, баримт (хүлээлцсэн акт) үйлдэнэ.
	2.11 Нийлүүлэгч нь барааг хүлээлгэн өгч, дагалдах үйлчилгээг үзүүлснээр Захиалагчид барааны өмчлөх эрх шилжинэ.
Барааны гарал үүслийн улс	2.12 Гэрээний дагуу нийлүүлэх Бараа нь Тендерт заасан улсын гарал үүсэлтэй байна.
	2.13 Нийлүүлэгчийн Тендерийг шалгаруулахад түүнд давуу эрх олгосон бол үнэлгээний явцад үнийг нь хийсвэрээр бууруулж тооцсон аливаа бараа нь заавал Монгол Улсын гарал үүсэлтэй бараа байна.
Баглаа боодол	2.14 Нийлүүлэгч барааг ГЕН-ийн 2.5-д заасан газар хүртэл тээвэрлэх явцад гэмтэх, муудах, дутах зэрэг доголдоос урьдчилан сэргийлэх сав, баглаа боодлыг ГТН-д заасны дагуу хангана.
	2.15 Сав, баглаа боодол, түүний хаягдал нь хүрээлэн буй орчинд учруулах сөрөг нөлөөллийг хамгийн бага байхаар сонгоно. Сав, баглаа боодолд хууль тогтоомжоор хориглосон материал ашиглахыг хориглоно.

	2.16	Нийлүүлэгч баглаа боодол, түүний дотор, гадна талд тэмдэглэгээ хийх, баримт бичгийг бэлтгэхдээ ГТН-д заасан шаардлага болон Захиалагчийн тухайн үед өгөх зааварчилгааг мөрдөнө.
Худалдааны нөхцөл	2.17	Гэрээнд Худалдааны нөхцөл (Incoterms)-ийг хэрэглэх бол тендерийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ-ны 20.6-д заасан нөхцөлийг ГТН-д тусгана.
	2.18	ГТН-д заагаагүй бол Incoterms 2020 Delivery Duty Paid /DDP/ нөхцөлөөр бараа нийлүүлэлтийн хуваарьт дурдсан газарт хүргүүлэхээр хэрэглэнэ.
Гүйцэтгэлийн баталгаа	2.19	Гүйцэтгэлийн баталгаа гаргуулахаар Өгөгдлийн хүснэгтэд заасан бол Нийлүүлэгч нь тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн З хувийн үнийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг холбогдох маягтын дагуу захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ. Төсвийн жил дамжин хэрэгжих гэрээний гүйцэтгэлийн баталгааг Нийлүүлэгч жил бүр шинэчлэн ирүүлнэ.
	2.20	Захиалагч дараах нөхцөл бий болсон тохиолдолд үүргийн гүйцэтгэлийг Нийлүүлэгчийн Гүйцэтгэлийн баталгаагаар үл маргах журмаар хангуулна:
	2.20.1	Нийлүүлэгч гэрээгээр хүлээсэн үүргээ аливаа шалтгааны улмаас гүйцэтгээгүй;
	2.20.2	Нийлүүлэгч гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй;
	2.20.3	Нийлүүлэгч гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон.
	2.21	Захиалагч гүйцэтгэлийн баталгаагаар үүргийн гүйцэтгэлийг хангуулсан нь Нийлүүлэгчээс алданги, хохирол шаардах эрхийг хязгаарлахгүй.
	2.22	ГЕН-ийн 2.8-д заасны дагуу хугацаа сунгагдсан тохиолдолд Нийлүүлэгч гүйцэтгэлийн баталгааг мөн хугацаагаар сунгуулна.
	2.23	Чанарын баталгаа шаардсан тохиолдолд ГЕН-ийн 4.11-д заасан Чанарын баталгаа гаргасан тохиолдолд Гүйцэтгэлийг баталгааг чөлөөлнө.
	ГУРАВ. ЗАХИАЛАГЧ	
Барааг хүлээн авах	3.1	Захиалагч нь барааг хүлээн авч, хүлээлцсэн баримт (хүлээлцсэн акт) үйлдэнэ.
Шалгалт, туршилт	3.2	Нийлүүлэх бараа, дагалдах үйлчилгээ, үйлдвэрлэлийн үйл явц Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерт нийцэж буй эсэхийг хянах зорилгоор Захиалагч шалгалт, туршилт явуулах эрхтэй. Шалгалт, туршилт хийх хугацаа, журмын талаар Захиалагч нь Нийлүүлэгчид бичгээр урьдчилан мэдэгдэнэ.
	3.3	Шалгалт, туршилтын явцыг тэмдэглэл үйлдэн талууд баталгаажуулах бөгөөд бараа, дагалдах үйлчилгээ доголдолтой тохиолдолд Захиалагч доголдлыг арилгуулахаар Нийлүүлэгчид мэдэгдэл хүргүүлнэ.

- 3.4 ГЕН-ийн 3.3-т заасан мэдэгдлийн дагуу Нийлүүлэгч барааны доголдлыг арилгах арга хэмжээ авна.
- 3.5 Барааг хүлээн авахаас өмнө Захиалагч шалгасан, туршсан байх нь хүлээн авах үед түүнийг дахин шалгах, турших болон шаардлагатай тохиолдолд барааг хүлээн авахаас татгалзах, доголдолтой холбогдуулж шаардлага гаргах Захиалагчийн эрхийг хязгаарлахгүй.
- 3.6 Шалгалт, туршилт хийхтэй холбоотой аливаа зардлыг Нийлүүлэгч хариуцна.
- Гэрээний үнэ**
- 3.7 Гэрээний үнийг Гэрээ баталгаажуулах маягтад заана.
- 3.8 Гэрээний үнэд хуулийн 40.4-д заасан үндэслэлээр тохируулга хийх эсэх, тохируулга хийх бол аргачлалыг ГТН-д заана.
- Төлбөр төлөх**
- 3.9 Захиалагч нь төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхийг үндэслэн ГТН-д заасан хугацаанд төлбөрийг Нийлүүлэгчид төлнө.
- 3.10 Нийлүүлэгчийн хүсэлтээр Захиалагч Бараа нийлүүлэх хугацааг ГЕН-ийн 2.8-д заасны дагуу сунгасан бол сунгагдсан хугацаагаар Захиалагчийн төлбөр төлөх хугацааг сунгагдсан гэж үзнэ.
- 3.11 Захиалагч нь гэрээний үүргийг зохих ёсоор гүйцэтгэсэн тухай баримтын хуулбар хувь болон бусад холбогдох баримтыг төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхэд хавсаргахыг шаардаж болно.
- 3.12 Захиалагч урьдчилгаа төлбөр төлөхгүй.
- 3.13 ГЕН-ийн 3.8-д заасны дагуу үнэ тохируулж, гэрээний үнэ өөрчлөгдсөн тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт орсноос хойш өөрчлөгдсөн үнийг баримтална.
- 3.14 Төлбөрийн нэхэмжлэх нь Монгол Улсын Үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэгдсэн байна.
- 3.15 Захиалагч нь алданги болон бусад төлбөр шаардах эрхтэй бол Нийлүүлэгчид төлөх төлбөрөөс суутгана.
- ДӨРӨВ. ЭРСДЭЛ БА ХАРИУЦЛАГА**
- Захиалагчийн хүлээх эрсдэл**
- 4.1. Захиалагч дараах эрсдэлийг хариуцна:
- 4.1.1. Барааг захиалагчид шилжүүлснээс хойш бараа нь ГЕН-ийн 1.1.14-д заасан болон бусад байдлаар гэмтсэн, устсан;
- 4.1.2. Нийлүүлэгч Барааг гэрээнд заасан хугацаанд хүлээлгэн өгөх тодорхой үйлдэл хийсэн боловч Захиалагч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүлээн аваагүй (доголдолтой бараанд хамаарахгүй) байх хугацаанд ГЕН-ийн 1.1.14-д заасан болон бусад байдлаар Бараа гэмтсэн, устсан.
- Даатгал**
- 4.2. Нийлүүлэгч нь барааг үйлдвэрлэх, тээвэрлэх, хадгалах, хүлээлгэн өгөх үед гарч болох эрсдэлээс хамгаалж ГТН-д заасны дагуу даатгуулж, даатгалын гэрээ, гэрчилгээний хуулбар хувийг Захиалагчид

- ирүүлнэ. Даатгалын хураамжийг Нийлүүлэгч хариуцна.
- Доголдол
- 4.3. Захиалагч бараа, дагалдах үйлчилгээг шалгаж, илэрсэн зөрчил, доголдлын талаар Нийлүүлэгчид мэдэгдэнэ.
 - 4.4. Захиалагч зөрчил, доголдлыг илрүүлэх зорилгоор барааны далд хэсгийг нээх, шалгалт, туршилт хийх эрхтэй.
 - 4.5. Захиалагч ГТН-д заасан баталгаат хугацаа эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаа дуусахаас өмнө зөрчил, доголдол арилгах тухай мэдэгдлийг нийлүүлэгчид өгнө.
 - 4.6. Доголдол арилгах мэдэгдэл өгсөн тухай бүр Нийлүүлэгч уг зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд өөрийн зардлаар арилгана.
 - 4.7. Нийлүүлэгч зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд арилгаагүй бол Захиалагч өөрийн зардлаар арилгана.
 - 4.8. Захиалагчийн гаргасан зардлыг Нийлүүлэгч Захиалагчид үл маргах журмаар төлнө.
 - 4.9. Захиалагч нь ГЕН-ийн 4.7-д заасан зардлыг Чанарын баталгаанаас суутгаж болох бөгөөд Чанарын баталгаа хүрэлцээгүй тохиолдолд илүү гарсан зардлыг Нийлүүлэгч нь Захиалагчид үл маргах журмаар төлнө.
- Чанарын баталгаа
- 4.10. Бараа, дагалдах үйлчилгээний баталгаат хугацааг ГТН-д заана.
 - 4.11. ГТН-д заасан бол чанарын баталгааг хангуулах зорилгоор баталгаат эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаанд Чанарын баталгаа гаргуулж болно.
 - 4.12. Нийлүүлэгч Чанарын баталгааг хуулийн 43.7-д заасны дагуу баталгаажуулж болно.
 - 4.13. ГЕН-ийн 4.12-д заасны дагуу баталгаажуулсан тохиолдолд Захиалагч барьцаалсан мөнгийг баталгаанд заасан дүнтэй тэнцэх хэмжээгээр олгоно.
 - 4.14. Баталгаат эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаанд Бараанд аливаа доголдол илрээгүй бол Чанарын баталгааг чөлөөлнө.
 - 4.15. ГЕН-ийн 4.7-д зааснаар Захиалагч доголдлыг арилгасан бол доголдол арилгахтай холбоотой гарсан зардал, хохирлыг суутгаж, баталгаат эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаа дуусмагц үлдсэн мөнгийг Нийлүүлэгчид олгоно.
 - 4.16. ГЕН-ийн 4.7-д заасны дагуу доголдлыг арилгасан тохиолдолд баталгаат эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаа хэвийн үргэлжилнэ.
 - 4.17. Нийлүүлэгч нь барааг хуваарийн дагуу буюу гэрээнд заасан хугацаанд нийлүүлээгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн
- Алданги

	дүнгээр ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Захиалагчид төлнө.
Оюуны өмчийн эрх зөрчих	4.18. Захиалагч нь төлбөр төлөх үүргээ хугацаандадаа гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Нийлүүлэгчид төлнө.
Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал	4.19. Барааг өмчлөх, эзэмших, ашиглах явцад гуравдагч этгээдийн оюуны өмчийн эрх зөрчигдсэн нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон бол буруутай тал нь хариуцлагыг хүлээж, холбогдон гарах зардал, хохирлыг арилгана.
Үүрэг гүйцэтгүүлэх нэмэлт хугацаа	4.20. Барааг гэрээнд заасан хугацаанд нийлүүлэх боломжгүйд хүргэсэн гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон тохиолдолд Нийлүүлэгч нь энэ тухай нэн даруй Захиалагчийн төлөөлөгчид бичгээр мэдэгдэнэ. Бичгээр мэдэгдэх нь хугацаа шаардахаар бол ГЕН-ийн 6.10-д заасан хэлбэрээр урьдчилан мэдэгдэж болно.
Гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах үндэслэл	4.21. Нийлүүлэгч нь Захиалагчаас зааварчилгаа өгөх хүртэл гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга замыг хайна.
	4.22. Захиалагч ердийн боломжит хугацаанд зааварчилгаа өгөх бөгөөд талууд харилцан зөвшлилцэж гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга хэмжээг авна.
	4.23. Гэрээг хэрэгжүүлэх Захиалагчийн зааварчилгаа, Нийлүүлэгчийн авсан арга хэмжээ үр дүнд хүрээгүй тохиолдолд Нийлүүлэгч ГЕН-ийн 2.7-д заасан хүсэлт гаргаж болно.
	4.24. Гэрээний нэг тал нь үүргийн зөрчил гаргасан тохиолдолд нөгөө талд үүргийн зөрчлийг арилгах нэмэлт хугацаа тогтоож, мэдэгдэл хүргүүлнэ. Нэмэлт хугацаа нь үүргийг гүйцэтгэх ердийн боломжит хугацаа байна.
	4.25. Иргэний хуулийн 226 дугаар зүйлд заасан үндэслэл бий болсон тохиолдолд эсхүл Нийлүүлэгч ГЕН-ийн 2.13-т заасныг зөрчсөн бол нэмэлт хугацаа тогтоохгүй байж болно.

ТАВ. ГЭРЭЭ ДУУСГАВАР БОЛОХ

Гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах үндэслэл	5.1. Захиалагч дараах үндэслэлийн аль нэг нь хангагдсан тохиолдолд гэрээнээс татгалзах эсхүл гэрээг цуцлах эрхтэй:
	5.1.1. Нийлүүлэгч гэрээнд заасан хугацаанд үүргээ гүйцэтгээгүй эсхүл зохих ёсоор гүйцэтгээгүйн улмаас Захиалагч үүрэг гүйцэтгэх нэмэлт хугацаа тогтоосон боловч нэмэлт хугацаанд гүйцэтгээгүй;
	5.1.2. Бараа нийлүүлэх хугацаанд Нийлүүлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн

- хугацаа дуусаж сунгагдаагүй, түдгэлзүүлсэн,
хүчингүй болсон;
- 5.1.3. Нийлүүлэгч ГЕН-ийн 6.5-д заасан үүргээ зөрчсөн нь тогтоогдсон.
 - 5.1.4. Нийлүүлэгч өөрийн тендерийн давуу эрх тооцуулсан нөхцөлийн дагуу гэрээний үүргийг биелүүлээгүй.
 - 5.2. Нийлүүлэгч тендерт оролцох буюу бараа нийлүүлэх явцдаа авлига өгсөн, залилах гэмт хэрэг үйлдсэн нь шүүх болон эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон.
 - 5.3. Захиалагч нь төлбөр хийх хугацаа хэтэрсэн тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш тогтоосон хугацаанд төлбөрийг төлөөгүй тохиолдолд Нийлүүлэгч гэрээг цуцалж болно.
 - 5.4. Нийлүүлэгч ямар ч тохиолдолд гэрээнээс татгалзах эрхийг хэрэгжүүлэхгүй.
 - 5.5. Гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах мэдэгдэлд гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах болсон үндэслэл, цаашид гэрээг дуусгавар болсонтой холбоотой авах арга хэмжээний тухай тусгасан байна.
- ЗУРГАА. БУСАД ЗҮЙЛ**
- | | |
|-------------------|--|
| Төлөөлөгч | <ul style="list-style-type: none"> 6.1. Талууд өөрийн төлөөлөгчийг томилж, томилсон төлөөлөгчийн мэдээллийг гэрээ баталгаажуулах маягтад заана. 6.2. Төлөөлөгчийн мэдээлэлд түүний эцэг (эх)-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, холбоо барих утас (ажлын болон хувийн), цахим шуудангийн хаяг тэмдэглэгдсэн байна. 6.3. Гэрээ хэрэгжүүлэх явцад төлөөлөгч солигдсон бол Төлөөлөгч солигдсон тухай болон түүний мэдээллийг агуулсан мэдэгдлийг нөгөө талд бичгээр хүргүүлнэ. 6.4. Төлөөлөгч нь төлөөлүүлэгчээс бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр эрх, үүргээ аливаа хэлбэрээр бусдад шилжүүлэхийг хориглоно. |
| Туслан гүйцэтгэгч | <ul style="list-style-type: none"> 6.5. Туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлж байгаа тохиолдолд Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерт зааснаас илуу хувийг туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлэхгүй байх үүрэгтэй. 6.6. Туслан гүйцэтгэгчийн аливаа зөрчлийг (хугацаа хэтрүүлэх, ажлын догонд гол гэх мэт) Нийлүүлэгч хариуцах бөгөөд Туслан гүйцэтгэгч өөрчлөгдсөн тохиолдолд ГЕН-ийн 2.3-д заасан журмыг баримтална. |
| Нууцлал | <ul style="list-style-type: none"> 6.7. Талууд гэрээг хэрэгжүүлэх явцад олж авсан хуулиар тогтоосон болон байгууллагаас нууц гэж нууцалж хамгаалалтад авсан аливаа мэдээллийг нөгөө тал зөвшөөрсөн эсхүл эрх бүхий байгууллага шаардсанаас бусад тохиолдолд гуравдагч этгээдэд задруулахгүй, дамжуулахгүй, нийтэд ил болгохгүй. |

- 6.8. Талуудын хувьд нууц мэдээллийг нөгөө талдаа ил болгож байгаа тохиолдолд нууц гэсэн тэмдэглэл хийж, нууцыг задруулахгүй байх мэдэгдлийг хамт өгнө.
- Мэдэгдэл
- 6.9. Гэрээний үүргийн гүйцэтгэлтэй холбоотой бүх мэдэгдэл (зөвшөөрөл, татгалзал, баталгаа, баталгаажуулалт, нэхэмжлэх, гэрчилгээ, шийдвэр, хүсэлт, захидал үүгээр хязгаарлагдахгүй) нь бичгээр үйлдэгдэнэ.
- 6.10. Гэнэтийн буюу давагдашгүй хүчиний шинжтэй онцгой нөхцөл байдал үүссэн тухай мэдэгдлийг ГЕН-ийн 6.9 -д зааснаас өөр хэлбэрээр мэдэгдэж болох бөгөөд мэдэгдлийг баталгаажуулж бичгээр хүргүүлнэ.
- 6.11. Мэдэгдлийг биечлэн хүргүүлэх эсхүл баталгаат шуудангаар гэрээ баталгаажуулах маягтад заасан Төлөөлөгчийн хаягаар илгээнэ.
- 6.12. Дараах тохиолдолд мэдэгдлийг хүлээн авсанд тооцно:
- 6.12.1. баталгаат шуудангаар илгээсэн тохиолдолд шууданд хийсэн өдрөөр, төлбөр төлсөн баримтыг үндэслэн;
- 6.12.2. биечлэн хүргүүлсэн мэдэгдлийг нөгөө талын төлөөлөх эрх бүхий этгээд хүлээн авсан огноогоор, тэмдэглэлийг үндэслэн.
- 6.13. Аль нэг тал нь ажлын газрын хаяг, утас, шуудангийн хаягаа сольсон тохиолдолд нөгөө талдаа нэн даруй бичгээр мэдэгдэнэ.
- 6.14. ГЕН-ийн 6.13-д заасан үүргээ биелүүлээгүйгээс үүсэх үр дагаврыг мэдэгдээгүй тал хариуцна.
- Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах
- 6.15. Дараах тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулна:
- 6.15.1. ГЕН-ийн 2.8-т заасны дагуу хугацаа сунгагдсан;
- 6.15.2. үнийн тохируулга хийсэн.
- 6.16. Гэрээний нэмэлт, өөрчлөлтөд талуудын эрх бүхий төлөөлөгч гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болно.
- 6.17. ГЕН-ийн 6.15-д зааснаас бусад тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахгүй.
- Маргаан шийдвэрлэх
- 6.18. Гэрээг биелүүлэхтэй холбогдон гарсан аливаа санал зэрэлдөөн, маргааныг талууд зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.
- 6.19. Талууд зөвшилцөн, шийдвэрлэж эс чадвал Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

ГЕН 2.5.	Бараа нийлүүлэх газар: “Тавантолгой түлш” ХХК-ийн Зүүн үйлдвэрийн байр
ГЕН 2.6.	Бараа нийлүүлэх сүүлийн хугацаа: Гэрээ байгуулсан өдрөөс хойш 60 хоногийн дотор
ГЕН 2.10.	Бараа хүлээлгэн өгөх нөхцөл: <i>Incoterms 2020 Delivery Duty Paid /DDP/ нөхцөлөөр бараа нийлүүлэлтийн хуваарьт дурдсан газар / Зүүн үйлдвэрийн/-т хүргүүлэн угсруулах</i>
ГЕН 2.14.	Баглаа, боодол: Барааг тусгай зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэн эцсийн цэгт хүргэнэ. Тээвэрлэх, хадгалах үедээ ус бороо, галын аюулаас бүрэн хамгаалагдсан зориулалтын саванд хийж барааны чанарыг алдагдуулахгүй байна.
ГЕН 2.17.	Худалдааны нөхцөл: <i>Incoterms 2020, Delivery Duty Paid (DDP)</i> “Тавантолгой түлш” ХХК-ийн Зүүн үйлдвэр
ГЕН 3.8.	Үнийн тохируулга хийх аргачлал: Тохируулахгүй тогтмол байна
ГЕН 3.9.	Төлбөр төлөх хугацаа: Захиалагч барааг хүлээн авч угсралт сууринуулалт хийлгэх гүйцэтгэлийн актын дагаа ирүүлсэн нэхэмжлэлийг үндэслэн гүйцэтгэлээр тухай бүр төлбөрийг шилжүүлнэ.
ГЕН 4.2.	Даатгал: Шаардахгүй
ГЕН 4.10.	Баталгаат хугацаа: 1 жил (Барааг ашиглаж эхэлснээс хойш доголдол илэрсэн тохиолдолд нийлүүлэгч өөрийн хөрөнгөөр сольж 30 хоногийн дотор нийлүүлнэ)
ГЕН 4.11	Чанарын баталгаа: Барааг “Тавантолгой түлш” ХХК-ийн Зүүн үйлдвэрт угсралт сууринуулалт хийсний дараа захиалагчын хяналтын холбогдох чанарын хяналт, мэдээлэл технологийн мэргэжилтэнүүд техникийн шаардлагыг хангасан тохиолдолд барааг хүлээн авна.
ГЕН 4.17.	Нийлүүлэгчийн төлөх алданги: Алданги тооцох эсэх: “Тийм” Алдангийн хувь: Хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.1 хувь байх ба энэ нь гэрээний үнийн дүнгийн 10 хувиас хэтрэхгүй байна
ГЕН 4.18.	Захиалагчийн төлөх алданги: Алданги тооцох эсэх: “Үгүй” Алдангийн хувь:

ГЭРЭЭ БАТАЛГААЖУУЛАХ МАЯГТ

[Тендер шалгаруулалтын нэрийг бичих] гэрээ.
Дугаар № [Тендер шалгаруулалтын дугаарыг бичих]

..... хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэрийг бичих] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [нийлүүлэгчийн нэрийг бичих] (цаашид “нийлүүлэгч” гэх) нь Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерийг хүлээн зөвшөөрч энэхүү гэрээг дараах нөхцөлөөр байгуулав.

Энэхүү гэрээ нь Захиалагч болон Нийлүүлэгчийн хооронд бараа нийлүүлэх, дагалдах үйлчилгээ үзүүлэх (цаашид хамтад нь “Бараа” гэх) болон үнэ төлөхтэй холбогдсон үүсэх харилцааг зохицуулна.

1. Энэ гэрээний дагуу нийлүүлэх Барааны үнэ нь [гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэлд заасан үнийн дунг тоогоор болон үсгээр бичих] төгрөг (цаашид “гэрээний үнэ” гэх) байна. Гэрээний үнэ нь санхүүжилтийн дээд хэмжээ байна.
2. Гэрээний үнийг Нийлүүлэгч [Нийлүүлэгчийн нэрийг бичих]-ийн харилцах [Банкны нэрийг бичих] банкны [дансны дугаар бичих] дугаар дансанд шилжүүлнэ.
3. Доор дурдсан баримт бичиг нь цаашид гэрээний хэсэг болно. (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:
 - 3.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
 - 3.2. Нийлүүлэгч тендер илгээсэн маягт;
 - 3.3. Гэрээний тусгай нөхцөл;
 - 3.4. Гэрээний ерөнхий нөхцөл;
 - 3.5. Гүйцэтгэлийн баталгаа;
 - 3.6. Техникийн тодорхойлолт;
 - 3.7. Бараа угсралт нийлүүлэлтийн хуваарь.
4. Гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлаар талуудыг дараах эрх бүхий этгээдүүд төлөөлнө. Үүнд:
 - 4.1. Захиалагчийн төлөөлөгчийн мэдээлэл
Эцэг/эх-ийн нэр:
Нэр:
Албан тушаал:
Ажлын утас:
Гар утас:
Цахим шуудан:
 - 4.2. Нийлүүлэгчийн төлөөлөгчийн мэдээлэл
Эцэг/эх-ийн нэр:
Нэр:
Албан тушаал:
Ажлын утас:
Гар утас:
Цахим шуудан:

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:
[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:
[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗАРЛАЛ

Огноо: **2024.08.16**

Тендер шалгаруулалтын төрөл: **Бараа нийлүүлж, угсралт сууринуулалт хийх**

Тендер шалгаруулалтын нэр: **Холбоо дохиолол камержуулалт худалдан авах**

Тендер шалгаруулалтын дугаар: **TTTXXK/20240102166**

Нийт төсөвт өртөг: **905,000,000**

Тендер шалгаруулалтын арга: **Нээлттэй**

- “Тавантолгой түлш” ХХК нь тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлага, шалгуур үзүүлэлт хангасан аж ахуй эрхлэгчийг тендер ирүүлэхийг урьж байна.
- Тендер шалгаруулалт нь дараах багцуудаас бүрдэнэ: “**Багцгүй**”
- Тендерийг **2024 оны 09-р сарын 06-ны өдрийн 10.00 цагаас** өмнө тендер шалгаруулалтын баримт бичигт зааснаар илгээх ба тендерийг **2024 оны 09 сарын 06-ны өдрийн 10 цаг 30 минутад** нээнэ.
- Тендерийн хувилбарт саналыг зөвшөөрөх эсэх: “**Зөвшөөрөхгүй**”
- Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй эсэх: “**Эрхгүй**”
- Тендер нь түүнийг нээснээс хойш **ажлын 30** ба түүнээс дээш өдрийн хугацаанд хүчинтэй байна.
- Тендерийн баталгаа шаардах эсэх: “**Тийм**”
Тендерийн баталгаа шаардах бол тендер шалгаруулалтын баримт бичгийн заасан үнийн бүхий тендерийн баталгааг холбогдох журмын дагуу цахим системээр ирүүлснээр тендер нээх болохыг анхаарна уу.
- Тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа эсэх: “**Үгүй**”
- Тендер шалгаруулалтыг хоёр үе шаттай зохион байгуулж байгаа эсэх: “**Үгүй**”
- Оролцогч цахим системийн үйлчилгээний хураамж төлснөөр тендер илгээх эрхтэй байна.

**Төв аймаг, Сэргэлэн сум, 1-р баг, Баянбүрд, Баян уулын баруун талд, Зүүн үйлдвэр А байрны 231 тоот, Худалдан авах ажиллагааны хэлтэс,
Утас: 77119400, Цахим шуудангийн хаяг: info@ttt.mn**